

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ 2023-2025 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023, 2024, 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

Орхон аймаг

Хэлэлцээрийн заалтын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Хэрэгжилтийг зохион байгуулах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Үр дүн	Хэрэгжилт	Үнэлгээ /хувиар/
Нэг. Нийгмийн харилцааны асуудал					
<p>1.1. Аймаг, сумын төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга ҮЭ-ийн байгууллага, Ажил олгогч эздийн холбоо, олон нийтэд танилцуулж, санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна. Байгууллагын төсвийг байгуулахдаа дээрх зарчмыг баримтална.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын СТСХ ХБТХОХ</p>	<p>Аймаг, сумдын ЗДТГ АҮЭХ АОЭХ</p>	<p>Олон нийтийн саналыг авч нэгтгэсэн аймаг, сумын төсвийн төслийг холбогдох ИТХ-аар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үйлдвэр, ААНБ-уудын төсвийн төсөлд ажиллагсад, ҮЭ-ийн хорооноос гаргасан саналыг тусгагдсан байна.</p>	<p>Аймгийн төсвийн төслийг боловсруулах явцад олон удаагийн хэлэлцүүлгүүд явагддаг бөгөөд ҮЭ-ийн байгууллага, Ажил олгогч эздийн холбооны төлөөллийг оролцуулсан төсвийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал хүсэлтийг төсөвт тусган ажилладаг.</p>	<p align="center">100%</p>
<p>1.2. Аймаг, орон нутгийн хэмжээнд иргэдийн хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой хөгжил бүтээх дэд хөтөлбөр, төслүүдийг боловсруулахад холбогдох салбаруудын хүрээнд ажиллагсад, мэргэжилтнүүд, нийгмийн түншлэлийн талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан саналыг тусгаж хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ ХБТХОХ ХХҮГ Эрдэнэт ШУТП</p>	<p>АҮЭХ АОЭХ</p>	<p>Холбогдох субъектуудын саналыг тусгасан хөгжил бүтээх дэд хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>Нийгмийн түншлэлийн талууд болох Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, төрийн байгууллага зэрэг гурван талаас бүрдсэн аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл тайлант онуудад "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу сургалт, уулзалт, зөвлөгөөн, хурал, холбогдох байгууллагуудаас санал</p>	<p align="center">100%</p>

				<p>авах дээд шатны байгууллагуудад хүргүүлэх зэрэг 47 ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. ХАБЭА-н зөвлөлийн НАВ.Erdenet.mn web сайтад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сарын аяны нээлт, зөвлөлийн ажлын төлөвлөгөө, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж болон шинэчлэгдсэн эрх зүйн актуудын талаарх 20 гаруй төрлийн мэдээллийг байршуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 15.8, Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хороог нийгмийн түншлэгч талуудын бүрэлдэхүүнтэйгээр Засаг даргын захирамжаар байгуулж, 2025 онд өөрчлөлт оруулж шинэчилсэн. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, ХАБЭА-н салбар зөвлөлийн хуралдаанууд тогтмолжсон. Зөвлөл тус бүрд нийгмийн түншлэгч талууд оролцоог жигд ханган ажиллаж байна. ХЭСЗөвлөлийн гишүүд хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалтад ажилласан.</p>	
<p>1.3. Аймгийн ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10/05 дугаар тогтоолоор баталсан “Орон сууцны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж түүний хэрэгжилтэд хяналт тавих, аймгийн дахин төлөвлөлтийн ажлын хэсэгт ҮЭХ, АОЭХ-ны төлөөллийг оруулан</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ОНӨГ</p>	<p>АОЭХ АҮЭХ</p>	<p>Тогтоолын хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо сайжирч, Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг нийт 27.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр зохион байгуулж байгаа бөгөөд 2025 оны 08 дугаар сарын байдлаар 4 блок ашиглалтад орсон. Тавдугаар Е блок-</p>	<p>100%</p>

хамтран ажиллана.				<p>15 орчим хувьтай баригдаж байна. Иргэдэд erdenet.mn цахим хуудсаар тухай бүр мэдээлэл өгч, цахим бүртгэл хийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан. 2023 оны 07 дугаар сард эхний ээлжийн 2 блок 104 айлын, 2024 оны 02 дугаар сард 3 дугаар ээлжийн 52 айлын, 2025 оны 03 дугаар сард 52 айлын, нийт 208 айлын орон сууцны байрыг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/606 тоот захирамжаар байгуулагдсан Уртын гол багт баригдаж байгаа 158 айлын орон сууцны байрыг ашиглалтад орсны дараа орон нутагт хүлээн авах, иргэдийн өргөдлийг шийдвэрлэж оруулах үүрэг чиглэл бүхий ажлын хэсэгт аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн М.Батцоож хамтран ажилласан.</p> <p>Дээрх орон сууцанд эрүүл мэндийн байгууллагын 5, боловсролын байгууллагын 19, төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллагын 11, бусад төрийн үйлчилгээний 16, нийт 51 албан хаагчийг хамруулсан.</p>	
1.4. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих оролцоог хангаж ажиллана.	Аймаг, сумдын ЗДТГ ХНЗГТБХ	АОЭХ АҮЭХ Холбогдох мэргэжлийн холбоод	Хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо сайжирсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 талт хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд төлөөлөл ажиллуулж, ҮЭ-ийн идэвхтэн, сонгуультнууддаа болон нийт гишүүд, ажилтнуудад мэдээлэл өгч ажилласан.	100%
Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах асуудал					
2.1. Орон нутгийн бизнес эрхлэгчид,	Аймгийн ЗДТГ-	ОНӨГ	Орон нутгийн	2023 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ,	100%

<p>аймгийн АОЭХ-ны гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж тэдгээрийн бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийлүүлдэг байх талаар нийгмийн түншлэлийн талууд хамтарч ажиллана.</p>	<p>ын ХБТХОХ АОЭХ</p>	<p>АҮЭХ Эрдэнэт ШУТП Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, ХК</p>	<p>бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний чанар, ажил үйлчилгээ сайжирч, ажлын байр, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт нэмэгдсэн байна.</p>	<p>ШШГЕГ нь 28 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчтэй нийт 9.5 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж ажилласан. “Ачит-Ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Гал сэнтий” ХХК нь 370 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 15.4 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагааг дэмжсэн. “Баясгалант Бат-Очир” ХХК, “Үрт Ундрэм” ХХК, “БЛГЯ” хоршоо зэрэг 17 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, 24 цэцэрлэг, 16 сургууль, Эрүүл мэндийн байгууллагад өөрийн тариалсан төмс, хүнсний ногоог нийлүүлсэн. “Уран хас” ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдын ажлын хувцас, “Гутал буян” ХХК нь “Ора металл” ХХК, “Мах маркет” ХХК, “Hard steel” ХХК-д нийт 400 хос ажлын гутал, “Урлахуйн жигүүр” ХХК нь Уран эгшиг урлагийн сургуулийн 1000 гаруй сурагчийн 3 хос дүрэмт хувцсыг оёж нийлүүлсэн. Мөн 2024 онд “Урлахуйн жигүүр” ХХК нь Уран эгшиг урлагийн сургуулийн 1200 хүүхдийн урлагийн хувцсыг урлан нийлүүлсэн. “Уран хас” ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилчдын ажлын хувцас, “Гутал буян” ХХК нь “Ора металл”, “Мах маркет” ХХК, “Hard steel” ХХК-д 200 хос гутал нийлүүлсэн. “Баяжуулагч-Одод” ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хор саармагжуулах бүтээгдэхүүний 40 хувийг, аймгийн 32 сургууль, цэцэрлэгт сүү, сүүн бүтээгдэхүүн, “Үржих таван эрдэнэ” ХХК Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т дотор мах, дайвар бүтээгдэхүүн нийлүүлж байна.</p>	
--	-------------------------------	---	---	--	--

<p>2.2. Удаан хугацаагаар ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэдийг байнгын ажлын байраар хангах, ажилд зуучлах, төрийн болон хувийн хэвшил, аж ахуй нэгж, байгууллагад шинээр бий болсон ажлын байрны бүртгэл мэдээллийг тогтмолжуулах, иргэдэд мэдээлж ажиллана.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ</p>	<p>АҮЭХ, АОЭХ</p>	<p>Иргэд байнгын ажлын байраар хангагдаж, ажилгүйдэл буурсан байна.</p>	<p>2023 онд 2266, 2024 онд 2705 ажлын байрны захиалга бүртгэгдсэн. 2025 оны эхний 08 сарын байдлаар 1089 ажлын байрны захиалга бүртгэгдсэн байна. 2023 онд 1125, 2024 онд 1080, 2025 оны эхний 8 сарын байдлаар 390 иргэн тус тус ажилд зуучлагдсан байна. Аймгийн ХХҮГ-аас ажлын байранд ажилтан авах захиалга хүлээн авч мэдээллийн сайтуудад байршуулан иргэдэд мэдээлж ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний JOB CENTER төвийг "Монголын хүний нөөцийн менежментийн холбоо" НҮТББ-ын дэргэдэх Хөдөлмөрийн хувийн биржтэй хамтарч захиргааны 4 дүгээр байранд 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн нээн ажиллуулж эхэлж байна. Тайлант хугацаануудад нийтдээ 2619 ажлын байр шинээр бий болсон.</p>	<p>100%</p>
<p>2.3. Нэмүү өртөг шингэсэн импортыг орлох бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг орон нутгийн баялаг бүтээгч, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд төр, захиргаанаас дэмжлэг үзүүлэх талаар нийгмийн түншлэлийн талууд хамтарч ажиллана.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ АОЭХ</p>	<p>ОНӨГ АҮЭХ Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, ХК</p>	<p>Төр, захиргаанаас үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>2023 онд Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих Прогресс төслөөс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн аж ахуйн нэгжүүдэд, тухайлбал "Баяжуулагч Одод" ХХК хатаасан аарц үйлдвэрлэл, "Цэцээ-Өндөрлөг" ХХК савхин эдлэл, "Арга билэг Арвин сүрэг" хоршоонд "Бэлгийн багц", "Үлэмж нандин" ХХК Care kids гэсэн чиглэлээр тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. "ITM Mongolia 2023" арга хэмжээнд орон нутгийн арьсан эдлэлийн Өндөрлөг брэнд, гар урлалын Сампин брэнд</p>	<p>100%</p>

			<p>бүтээгдэхүүнийг оролцуулан үйл ажиллагааг дэмжсэн. “Эрдэнэт хивс”, “Эрдэнэт кашмер” ХХК-ийн 4 нэр төрлийн 13 нэрийн бүтээгдэхүүн баталгаажуулалтад хамрагдан, тохирлын гэрчилгээ авч бүтээгдэхүүнээ экспортолж байна. 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 8, сүүний 3, гурил, тэжээлийн 4, ноос ноолуурын 4, арьс ширэн бүтээгдэхүүний 2, нийт 24 үйлдвэр ажиллаж байна. Үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 2, нийт 10 аж ахуйн нэгжийн 14 нэр төрлийн 143 нэрийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөхөд болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлсэн нь нийт үйлдвэрлэлийн 35.2 хувь нь баталгаажуулалтад хамрагдсан байна. “Эрдэнэт кашмер” ХХК технологийн шинэчлэл хийснээр жилдээ 4400 тн ноос угаах хүчин чадалтай болж өргөжсөн нь өмнөх оноос 2.5 дахин илүү хүчин чадалтай болж, гэр ахуйн хэрэглээний оёмол бүтээгдэхүүн, ноолуур болон ноосон бэлэн хувцсыг үйлдвэрлэж бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлсэн. Мөн тус компанийн сүлжмэлийн үйлдвэрт Герман улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж суурилуулж хүчин чадлаа</p>	
--	--	--	--	--

			<p>нэмэгдүүлснээр сүлжмэл хувцасны үйлдвэр жилд 11000 ширхэг цамц, оёдлын үйлдвэр нь жилд 90000 ширхэг оёмол бүтээгдэхүүн, нэхмэлийн үйлдвэр нь жилд дунджаар 50000 метр тэмээ, хонь, сарлагийн ноос, хөөврөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж ОХУ, Европын холбооны орнуудад экспортолж байна. Эрдэнэт хивс ХХК-иас ноолуурын угаах цехэд 2 төрлийн сэгсрэх машин суурилуулснаар хог хаягдлыг хуурайгаар нь ачиж зайлуулдаг болсноор лагийн хэмжээ буурсан. Ажлын гутал, эсгий табчик үйлдвэрлэдэг "Мөнх баян алт" ХХК нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төсөлд хамрагдаж тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийснээр гар ажиллагааг 40-50 хувь хөнгөвчилж ажлын бүтээмж нэмэгдэн, жилд дунджаар 2500–3000 хос эсгий табчик үйлдвэрлэн ОХУ руу экспортолж байна.</p> <p>2025 оны 09 дүгээр сард Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд зохион байгуулагдсан “Уул уурхайн 7 хоног” арга хэмжээнд “Ачит андага” ХХК-ийг дэмжин оролцуулснаар тус газар нь Хөтөлийн цемент шохойн үйлдвэр, Монгол Рос цветмет, Заамрын уурхай зэрэг газарт артишокны ундаа, эхонаци ундаа зэргийг нийлүүлэх хамтын ажиллагаа үүсгэхээр холбоо тогтоосон. Тус аж ахуйн нэгж нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэхээр ажиллаж</p>	
--	--	--	---	--

<p>2.4. Хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн НДШ төлөлтийн байдалд нийгмийн түншлэлийн талууд хяналт тавьж ажлын байр нэмэгдүүлэлт, зохистой хөдөлмөрийн бодлого хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ НДГ АОЭХ</p>	<p>ХХҮГ, АОЭХ</p>	<p>Хяналтын тогтолцоо сайжирч, ажлын байр нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөрийн бодлого хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>байна. 2023 онд Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч төлөвлөгөөний дагуу боловсруулах 7, барилгын салбарын 5, боловсролын 2, нийт 14 байгууллагыг хяналт шалгалтын хуудсаар 39 үзүүлэлтийн дагуу шалгаж 5 заалтаар 3 албан шаардлага өгч 85 хувийн үр дүнтэй, хэрэгжилтийг 100 хувь хангуулсан. НДГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас нийт 26 аж ахуйн нэгж, байгууллагын 11181.2 сая төгрөгийн цалингийн сантай 1304 даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод шалгалт хийж өр авлага барагдуулахад шат дараалсан арга хэмжээ авч 2038.5 сая төгрөгийг барагдуулан ажиллаж, тухайн ажилчдын нийгмийн баталгааг хангаж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2024 онд нийт 105 байгууллагын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж, цалин болон төрлийн залруулгын 42 дүгнэлт бичиж, 52 зөрчилд улсын байцаагчийн акт болон Зөрчлийн тухай хуулийн хялбаршуулсан журмаар нийт 10.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 4.0 сая төгрөгийн алдангийг нийгмийн даатгалын санд, нийт 14.5 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Үүнээс Зөрчлийн тухай хуулиар 25 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж хуульд заасан хугацаанд төлөгдөөгүй орхигдуулсан зөрчилд 7.7 сая төгрөгийн торгуулийг</p>	<p>100%</p>
---	-------------------------------------	-------------------	--	--	-------------

				<p>тавьж 100 хувь бүрэн барагдуулан ажилласан. Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан дотогшоо 8, гадагшаа 3, нийт 11 шалгалт хийж, шалгалтаар илэрсэн 73.9 сая төгрөгийн төлбөрийн зөрчлөөс 49.7 сая төгрөгийг буюу 67.3 хувийг барагдуулсан. Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр төлөвлөгөөнд тусгасан 15 байгууллагаас 15 ажил олгогчид шалгалт хийж, шалгалтын явцад 2 байгууллагад зөрчлийн хэрэг нээж 2000 нэгжээр торгох шийтгэл оногдуулж, 4 даатгуулагчийн 1.6 сая төгрөгийн хохирол нөхөн төлбөрийг 100 хувь төлүүлэн буруу тайлагнасан, даатгуулагч орхигдуулсан зөрчлийг нөхөн залруулан ажилласан.</p> <p>2025 онд улсын байцаагчийн акт 10 байгууллагад 9.2 сая төгрөг, цалингийн залруулга 12, төрөл залруулга 9 хийгдсэн. 12 иргэн, 23 байгууллагад зөрчлийг хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж 8.5 сая төгрөгийн торгуулиас 82.5 хувь барагдуулж, 238.6 сая төгрөгийн шимтгэл алданги нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж 70.32 сая төгрөгийг төлүүлж 29.5 хувь барагдуулж, 3 байгууллагын өр авлага, алдангид ногдуулсан 166.8 сая төгрөг, 1.5 сая төгрөгийн торгуулийг шүүхэд хандаж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--

<p>2.5. Баян-Өндөр, Жаргалант сумдын ажил хийх хүсэлтэй ажилгүй иргэдийг хотын зам талбай засаж тохижуулах, цэцэрлэгжүүлэх, орчны байгалийг сэргээн хамгаалах, малын тэжээл хадлан өвс бэлтгэх, үр тариа, хүнсний ногоо тариалах, ургац хураах, мод түлээ бэлтгэх зэрэг нийтийг хамарсан ажилд оролцуулан түр ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах, түр болон улирлын ажлын байр бий болгоход нийгмийн түншлэлийн талууд хамтарч ажиллана.</p>	<p>Аймаг, сумдын ЗДТГ ХХҮГ</p>	<p>БОГ ХХААГ ХТГ АҮЭХ АОЭХ</p>	<p>Иргэдийн хөдөлмөр эрхлэлт, бодит орлого нэмэгдэж, ядуурал буурсан, ажилгүйдэл багассан байна.</p>	<p>2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа 550 иргэнийг нийтийн эзэмшлийн хог цэвэрлэх, шарилж устгах түр ажлын байранд ажиллуулж 110.0 сая төгрөгийн урамшууллыг ХЭДСангаас олгосон. 2024 онд Баян-өндөр сумын ЗДТГ, Байгаль орчны газартай хамтран Булган аймгийн зэргэлдээ сумдын хилийн бүс нутгийн ой мод, гуу, жалга, голын голдирол дагуу хуримтлагдсан эзэнгүй хог хаягдал болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог цэвэрлэх ажилд 286 иргэнийг ажиллуулж, 51.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. 2025 ХЭДСанд хөрөнгө төсөвлөгдөөгүй тул нийтийг хамарсан ажил хийгдээгүй. Жил бүрийн ургац хураалтад Орхон аймгийн Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төв, Хөдөө аж ахуйн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудыг ажиллуулж байна. 2023 онд нийт 462 оюутан, 35 цэргийн албан хаагч, 300 гаруй гэрээт ажилтан ажиллуулсан. 2024 оны намрын ургац хураалтын үеэр газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 60 цэрэг, Орхон аймаг дахь Политехникийн коллежийн 162 оюутныг гэрээгээр ажиллуулсан. 2025 онд ургац хураалтын ажилд 800 гаруй иргэнийг түр ажлын байраар хангаж байна.</p>	<p>100%</p>
<p>2.6. Үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад зориулан дэмжлэг үзүүлж буй</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ НБХ</p>	<p>Сумдын ЗДТГ ХХҮГ ХХААГ</p>	<p>Холбогдох төсөл, хөтөлбөрт хамруулж, ажлын</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл</p>	<p>100%</p>

<p>зээлийг сонирхсон хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, ажлын байр болон бизнесийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлнэ.</p>	<p>СТСХ</p>	<p>Эрдэнэт ШУТП АОЭХ</p>	<p>байрыг нэмэгдэж, ядуурал тодорхой хэмжээнд буурсан байна.</p>	<p>ажиллагааг 2 үе шаттайгаар зохион байгуулан ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 31 иргэнд 150.0 сая төгрөг, иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 42 иргэнд 400.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэгт 28 иргэнд 280.0 сая төгрөг, нийт 101 иргэнд 830.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэгийг олгосон. Үүний үр дүнд 101 ажлын байр хадгалагдаж, 59 шинэ ажлын байр бий болсон.</p> <p>Залуучуудын Старт-ап арга хэмжээний хүрээнд ХХҮЕГ-аас сургалтын эрх авсан “Шинэ эхлэл цэг” ТББ-ын сургалтын төвтэй хамтран зохион байгуулж сургалтад 65 бизнесийн санаатай шаардлага хангаж байгаа залуусыг оролцуулж 4 баг шалгарч хурдасгуур хөтөлбөрт хамрагдан эцсийн шалгаруулалтаар 1 баг шалгарч 10.0 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж шинээр 2 ажлын байр нэмэгдсэн.</p> <p>Жижиг зээлийн санхүүжилт 13 иргэн дэмжигдэж 306.0 сая төгрөгийн санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Төрийн банкаар дамжуулан олгож, 14 ажлын байр хадгалагдан шинээр 17 ажлын байр бий болсон.</p> <p>2023 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас журмын</p>	
--	-------------	----------------------------------	--	---	--

				<p>шаардлага хангасан 5 төсөлд 894.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон.</p> <p>Засгийн газраас хэрэгжүүлж буй хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон.</p> <p>2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсний мөөг, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 17 ахмадад 85.0 сая төгрөг, иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 14 иргэнд 140.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 13 иргэнд 130.0 сая төгрөг, малжуулах арга хэмжээнд 8 хүнд 64.0 сая төгрөг, шилдэг старт-ап залуучуудын бүлгийн 1 төсөлд 10.0 сая төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 44 ахмадад 47.5 сая төгрөг, нийт 97 иргэнд 476.5 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгож, үүний үр дүнд 79 ажлын байр хадгалагдаж, 68 шинэ ажлын байр бий болсон байна.</p>	
--	--	--	--	---	--

				<p>Санхүүгийн дэмжлэг болон жижиг зээлд хамрагдсан хүчин төгөлдөр гэрээтэй, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг нийт 9 иргэнд 8.9 сая төгрөгийн түрээсийн дэмжлэг олгож үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.</p> <p>2024 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 8 аж ахуйн нэгж, байгууллагад 1271.5 сая төгрөг, Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлээс 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 хоршоонд 250.0 сая төгрөг, “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд 30 хоршоонд 4.9 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 55 ажлын байр шинээр нэмэгдсэн байна. Аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тусгай сангаас 7 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 265.8 сая төгрөгийн зээл олгогдож, нийт 43 аж ахуйн нэгж, байгууллага, 7 иргэнд 7.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон.</p> <p>Хүнс, худалдааны чиглэлийн 2 аж ахуйн нэгж 900.0 сая төгрөгийн зээл авч, хиаман төрлийн бүтээгдэхүүн, талхны нэр төрөл 3-аар нэмэгдэж, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн.</p> <p>Best хөтөлбөртэй хамтран “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн Ногоон бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрийн сургалт 1, Хүнсчдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх, үйлдвэрлэгчийг</p>	
--	--	--	--	--	--

				<p>чадавжуулах уулзалт, сургалт 2, нийт 3 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 89 үйлдвэрлэгчийг хамруулан зах зээлд суурилсан эко шошгожуулалт, ногоон баталгаажуулалтын системийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн тэдний дадал, зан төлөвөө өөрчлөн чадавжих сургалтаар хангаж, ногоон санхүүжилтийн эх үүсвэртэй болгох замаар тойрог эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2025 онд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсний үйлдвэрлэл, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа нийт 70 иргэнд 687.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд 70 ажлын байр хадгалагдаж, 50 шинэ ажлын байр бий болсон байна. Бүсчилсэн өдөрлөгүүд хийж, нийт 679 иргэн хамрагдсан байна.</p> <p>2025 онд ЖДҮХС-аас 7 төсөлд 900.0 сая төгрөг, Атар-4 аяны хүрээнд 1 аж ахуйн нэгж, байгууллага, 4 иргэнд 475.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 8 хоршоонд 572.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 82 хоршоо шинээр байгуулагдаж, 47 хоршооны 166 малчинд 6.1 тэрбум</p>	
--	--	--	--	--	--

				<p>төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож, 42 шинэ ажлын байр нэмэгдсэн. Мөн 41 хоршооны гишүүн 123 малчин өрхөд 3.1 тэрбум төгрөгийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан байна. Өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд “Наадмын гангараа” үзэсгэлэн, өдөрлөг, арга хэмжээг А.Амарын талбайд зохион байгуулж, оёдлын салбарын 33, гар урлалын салбарын 25 үйлдвэрлэгч оролцож 31.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p>	
<p>2.7. Ажлын байрыг хадгалж, сул орон тоо гарахад өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан, тодорхой хэмжээгээр шинээр ажлын байр бий болгосон, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжиж бараа, бүтээгдэхүүнийг нь худалдан авсан ААНБ, хувийн хэвшлийн шилдэг тэргүүний ажил олгогч, эздийг шалгаруулан урамшуулах буюу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааг нь сурталчлан алдаршуулах үйл ажиллагааг нийгмийн түншлэлийн талууд хамтарч зохион байгуулж төрийн дээд шагнал Монгол Улсын цол хүртээх, одон, медальд тодорхойлно.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ</p>	<p>Сумдын ЗДТГ ГБХЗХГ АОЭХ</p>	<p>Ажлын байрыг хадгалж, шинээр ажлын байр бий болгож иргэдийг тодорхой хэмжээгээр ажлын байраар хангасан ААНБ, хувийн хэвшлийн шилдэг тэргүүний ажил олгогч, эздийг урамшуулж алдаршуулна.</p>	<p>2022-2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчийн урамшуулалд 12 сараас дээш хугацаагаар 6 иргэнийг ажлын байраар хангасан 6 аж ахуйн нэгжид 28.3 сая төгрөгийн урамшуулал олгосон. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5 ажил олгогч, аж ахуй нэгж байгууллага 6 ажлын байранд гэрээ байгуулан ажиллаж байна. Ажил олгогчийг дэмжих урамшуулалд 2023 онд 3 байгууллагын 4 ажлын байранд гэрээ байгуулсны дагуу 2024 онд 1 аж ахуй нэгж байгууллагын гэрээг дүгнэж 2 ажлын байранд 14.5 сая төгрөгийн ажил олгогчийн урамшуулал олгосон. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөлд нийт 7 байгууллын 21 ажлын байранд урамшуулал авах хүсэлт ирүүлснээс 2 аж ахуйн нэгжийн 5 ажлын байрны урамшуулалд 9.9 сая төгрөгийн</p>	<p>70%</p>

				урамшуулал олгогдсон. Гэрээ байгуулсан “Зэс эрдэнэ” ХХК, Ачит эмнэлэг, “Анд энерги” ХХК, “Ачих Ихт” ХХК нь гэрээний хугацаанд ажилтнууд нь гарсан тул гэрээ байгуулахаас татгалзсан. “Очир Увидас” ХХК-ийн гэрээг дүгнэхэд гэрээний шаардлага хангахгүй байсан тул урамшуулал олгогдохгүй болсон. 2025 онд ажил олгогчийн урамшуулалд 1 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна.	
2.8. Төрийн болон хувийн хэвшлийн үйлдвэр, ААНБ өөрийн санаачилга, хөрөнгөөр тодорхой мэргэжлээр ажилтныг сургаж, ажилгүй иргэдэд шинэ мэргэжил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтыг сайн зохион байгуулсан ажил олгогчдыг дэмжиж төсөл, хөтөлбөрөөс зарим сургалтуудыг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ	АҮЭХ АОЭХ	Ажил олгогчдын зохион байгуулсан зарим сургалтуудын зардлыг холбогдох төсөл, хөтөлбөрөөс санхүүжүүлж, дэмжлэг үзүүлсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023, 2024, 2025 оны төсөвт үйлдвэр дээрх сургалт зохион байгуулах төсөв батлагдаж ирээгүй.	Үнэлэх боломжгүй
2.9. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй, зорилтот бүлгийн иргэд, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдийг үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалтын хэлбэрээр богино хугацаанд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг эрх бүхий мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хамтран зохион байгуулна.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ	ГБХЗХГ БГ АҮЭХ АОЭХ	Зорилтот бүлгийн иргэд, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд зориулсан сургалтыг зохион байгуулсан байна.	ХХҮЕГ-аас эрх авсан "Алтан алхам" сургалтын төв, Насан туршийн боловсролын төв зэрэг байгууллагуудтай хамтарч ерөнхий боловсролын түшиц 7 сургуулийн 8 дугаар ангийн 329 сурагч, хорих ангид хүмүүжиж байгаа 40 иргэн, ажил хайгч 31 иргэн нийт 400 иргэнд бүлгийн зөвлөгөө, 250 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, нийт 650 иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч 5.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. 2023 оноос хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээг	100%

				<p>шинээр нэвтрүүлэн 800 иргэнийг хамруулснаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг нийт 1450 иргэнд үзүүлсэн.</p> <p>2024 оны ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг Ерөнхий боловсролын 9 бүлгийн 8, 9 дүгээр ангийн 636 сурагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 437 дугаар нээлттэй хорих ангид хүмүүжигч 120 иргэн нийт 756 иргэдэд ХХҮЕГ-аас сургалтын эрх авсан Эм Эс Девелопмент консалтинг ХХК-ийн дэргэдэх мэргэжлийн сургалтын төвтэй гэрээлэн зохион байгуулсан. Тус сургалтад хамрагдсан суралцагчдыг “Мэргэжил сонголт-Миний ажил” төсөлд хамруулан ажилласан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 373 иргэн хамрагдаж 42.9 сая төгрөг зарцуулагдаж иргэд хөдөлмөр эрхлэх суурь ур чадварын болон мэргэжлийн, цахим ур чадвар эзэмшиж, хөдөлмөр эрхлэх боломж бүрдсэн. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хүрээнд иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулан, тогтвортой ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжих зорилгоор Орхон Политехникийн коллежтой хамтран ажилгүй 70 иргэнийг 7 мэргэжлээр мэргэжил олгох сургалтад хамруулж сургалтын төлбөр, хоол, унааны зардалд 27.9</p>	
--	--	--	--	--	--

				<p>сая төгрөг зарцуулсан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрх авсан Монголын удирдлага шинэчлэл менежментийн академи НҮТББ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 100 иргэнийг төсөл бичих 1 өдрийн, бизнесээ хөгжүүлэх 2 өдрийн сургалтад хамруулж сургалтын зардалд 3.9 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хосолсон сургалтыг Улаанбаатар хотын Сонор сургалтын төвтэй хамтран 2 мэргэжлээр 53 иргэнийг хамруулж 6.6 сая төгрөгийг санхүүжилт олгосон.</p> <p>2025 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институтээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын үйл ажиллагааны хүрээнд Чадамжид суурилсан танхимын мэргэжлийн болон ур чадварын цахим сургалтыг 2 үе шаттай зохион байгуулахаар төлөвлөсний дагуу 1 дүгээр үе шатын бүртгэлд 163 иргэнийг бүртгэсэн. Үүнээс хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд 135 иргэн хамрагдаж бүртгэл нь баталгаажсан. Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээнд 209 иргэн, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг 18 иргэн, ажил</p>	
--	--	--	--	--	--

				мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө мэдээллийн үйлчилгээнд бүлгээр 128 иргэн, ганцаарчилсан үйлчилгээнд 81 иргэн хамрагдсан байна.	
2.10. Төрийн болон төсөвт байгууллага, хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил олгогчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн хамгааллын талаарх сургалтыг жил бүр нийгмийн түншлэлийн талууд, холбогдох байгууллагуудын оролцоотойгоор хамтран зохион байгуулна.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ	АҮЭХ АОЭХ	Холбогдох сургалтыг зохион байгуулж, ажил олгогчдын чадавх, хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Аймгийн ХАБЭА-н зөвлөлөөс тайлант хугацаанд Хөдөлмөрийн тухай хуулийг олон нийтэд сурталчлах, таниулах арга хэмжээний хүрээнд байгууллагын цахим хуудсаар мэдээлэл бэлтгэн цувралаар хүргэж, 11 аж ахуйн нэгж байгууллага, 5 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, 11 байгууллагын хамтын гэрээг хүлээн авч хянан бүртгэсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2024 онд хийх ажлын төлөвлөгөөг 4 ажил зохион байгуулж 10.0 сая төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөнд 5 зорилт 25 арга хэмжээ зохион байгуулж 5.0 сая төгрөг орон нутгийн төсвөөс зарцуулсан. ХАБЭА-н сарын аяны хүрээнд 11 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Нийгмийн түншлэлийн талуудын байгууллагууд болон Нийгмийн даатгалын газар, Жаргалант сумын ХАБЭА-н зөвлөлтэй хамтран ажиллаж, сарын аяны нээлтийн үйл ажиллагааг "Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе" уриан дор зохион байгуулсан. Сарын аяны хүрээнд нийт 5 сургалт, 2 төрлийн зөвлөмж, малчдад зориулсан гарын авлага, Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг	100%

				<p>хүндэтгэх зул өргөх үйл ажиллагаа, халуунаас үүдэлтэй стресс, бухимдлаас урьдчилан сэргийлэх баннер зэргийг хийж бэлтгэн нийгмийн түншлэлийн 3 талын цахим хуудас болон hab.erdenet.mn веб сайт, ETV телевизээр мэдээлэл хүргэсэн. Бэлтгэсэн зөвлөмжийг сургалтад хамрагдсан иргэд болон томоохон худалдааны төв, 30 гаруй байгууллагын 10000 гаруй ажилтан албан хаагч нарт хүргэсэн. 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ХАБЭА-н ерөнхий ойлголт, ХАБЭА-н тухай хууль, асбестын хор нөлөө, эрсдэлийн үнэлгээний арга зүй сэдвүүдээр 5 байгууллагын 206 ажилтан албан хаагчдад 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 32, 37 дугаар зүйлийн дагуу 13 байгууллагын хамтын гэрээг хүлээн авч хянан бүртгэсэн. Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо 12 иргэний өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн.</p> <p>2025 онд ХАБЭА-н зөвлөл 12 хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 80 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, 80 аж ахуйн нэгж, байгууллагад 20 гаруй удаагийн сургалт, арга хэмжээ нөлөөллийн ажлууд зохион байгуулж 250 орчим албан хаагчид хамрагдсан байна.</p>	
--	--	--	--	--	--

<p>2.11. Хотын усан хангамж, инженерийн шугам сүлжээг сайжруулах төслийг хэрэгжүүлэхэд аймгийн хэмжээнд барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах чиглэлийг баримтална.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ГХБХБГ</p>	<p>ХЗА АОЭХ ЭУДТС ОНӨХК</p>	<p>Холбогдох ААНБ-уудыг тухайн төсөлд хамруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p>	<p>Инженерийн шугам сүлжээ шинээр хийгдэж ажлуудад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг компануудыг хамруулан ажиллаж байна. 2022 онд Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭДЦС ТӨХК-иас 9 дүгээр цэг хүртэлх Ду720мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих ажлын гүйцэтгэгчээр "Эрин гүрэн" ХХК шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа ба одоогийн байдлаар 800 м дулааны шугам угсралтын ажил хийгдсэнээр ажлын гүйцэтгэл 80%-тай байна.</p> <p>2024 онд орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажилд 895.2 сая төгрөгийг батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>2024 онд Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Бүрэнбүст багийн цэвэр усны шугамын ажилд 691.1 сая төгрөг, Уурхайчин багийн цэвэр усны шугамын ажилд 833.5 сая төгрөг, Хүрэнбулаг багийн УДДТ №4-2-ын гадна 5 хос 1 км шугам шинэчлэх ажилд 1.0 тэрбум төгрөг тус тус батлагдсан ба одоогоор тендер сонгон шалгаруулалт хийн Пристиж инженеринг ХХК шалгараад байна.</p> <p>2021-2023 онд аваарын байдалтай байсан 12 ажилд нийт 2.1 тэрбум зарцуулсан бол 2024 онд болзошгүй аваарын зардлаар 32 ажилд 1.8 тэрбум төгрөг зарцуулан инженерийн шугам сүлжээний хэвийн байдлыг хангасан.</p> <p>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Баян-Өндөр сумын Говил баг Илгээлт, Баянбулаг баг "Гок гарден" орон</p>	<p>90%</p>
--	--------------------------------------	---	--	--	------------

				<p>сууцны хотхоны баруун хойд талд шинээр барих шаардлагатай ус дулаан хуваарилах төвийн газрыг аймгийн Засаг даргын А/313 дугаар захирамжаар “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-д эзэмшүүлэн, инженерийн хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлын зургийн даалгаврыг холбогдох хангагч байгууллагуудтай зөвшилцөн боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулсан.</p> <p>Баянбулаг багт шинээр ус дулаан хуваарилах төвийг барих ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Ахин үндрах” ХХК шалгаран гүйцэтгэж байгаа бөгөөд 60 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	
<p>2.12. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэдийн оролцоотойгоор 2023 онд 1304.9 мянган, 2024 онд 2167.2 мянган, 2025 онд 4245.6 мянган, нийт 7717.7 мянган мод тарих замаар, хөрсний бохирдлыг бууруулж, усны нөөц нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ БОГ СДОА</p>	<p>Сумдын ЗДТГ ХЗА ЦНБГ СГСГЗ</p>	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж, нийт 7,717,700 мод тарьж ургуулснаар тодорхой хэмжээнд хөрсний бохирдол буурч, усны нөөц нэмэгдсэн байна.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2022 онд 1234847 ширхэг мод, 2023 онд Дэнж багийн нутаг дэвсгэр Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Жаргалант суманд 6.6 га-д газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал гол,</p>	<p>50%</p>

			<p>Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэн булгийн ам зэрэг газруудад 12.66 га талбайд нийт 1888068 ширхэг мод тарьсан. 2024 онд Бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлын хүрээнд Хүрэнбулагийн аманд 3 га талбайд, Эрдэнэтийн Дулаан цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, Шанд багийн овоот толгойд 4.7 га талбайд, Эрдэнэт хаалганы урд хэсэгт 5 га, Хангал голын голдирол дагуу 17 га нийт 30.7 га талбайд нийт 1474671 ширхэг мод тарих олон талт ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2024 онд таримал ойн хэмжээг 30.7 га талбайгаар нэмэгдүүлж, өссөн дүнгээр 123.46 га талбайд мод тарьж, ойн төгөл, зурвас байгууллаа. Аймгийн Засаг даргын 2025 оны “Бүх нийтээр мод тарих хаврын ажил зохион байгуулах тухай” А/360 дугаар захирамжаар мод тарих ажлын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Жаргалант сумын нутаг дэвсгэр болон Баян-Өндөр сумын Дэнж баг, Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Вокзалын ойн зурвас 2.5 га, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэнбулагийн ам зэрэг газруудад 48.3 га талбай газарт нийт 141200 ширхэг мод тарих олон талт ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2023-2025 онуудад нийт өссөн дүнгээр таримал модны хэмжээг 3503939 ширхэгт хүргээд байна. Мод</p>	
--	--	--	--	--

				тарих хүсэлтэй иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор мод бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, мод тарих хар шорооны нөөцийг бүрдүүлэх болон усалгааны систем зэрэг бэлтгэл ажлуудыг ханган ажилласан.	
2.13. Дотоодын түүхий эд, нөөц бололцоонд суурилсан хөдөө аж ахуй, уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүд байгуулах үйлдвэрлэлийн туршилт, судалгаа хийгдсэн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ХХҮГ ХХААГ	Эрдэнэт ШУТП	Тухайн төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж, ажлын байр нэмэгдсэн байна.	2023 онд “Эко будаг” ХХК нь 84 нэр төрлийн эко будаг, дагалдах материалын хамт үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж эхэлсэн. 2024 онд Эрдэнэт ШУТП нь таримал мөөгний ухаалаг хүлэмж, үйлдвэрийн байр, ус тусгаарлагч үйлдвэрлэлийн технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, барилгын салбарын үйлдвэрлэгчдийг чадавхжуулах “LEVEL UP” дэд хөтөлбөрийг эхлүүлж, хөтөлбөрийн хүрээнд 10 удаагийн шаталсан сургалт зохион байгуулсан. Барилгын хаягдлыг хэрхэн дахин ашиглах талаар 2 удаагийн сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж 15 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон. Сургалтын үр дүнд 2 аж ахуйн нэгж, байгууллага барилгын хаягдал хөөс болон хуванцар, гялгар уут дахин боловсруулж блок, эмээл, хашаа, шал зэрэг барилгын болон ахуйн зориулалттай бүтээгдэхүүн хийж зах зээлд худалдан борлуулахаас гадна томоохон аж ахуйн нэгжүүдэд захиалгаар нийлүүлж байна. “Ачит андага” ХХК нь артишок тариалж артишок, эхонаци ундаа үйлдвэрлэж аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж байна. Тус аж ахуйн нэгж	100%

				нь 360 мкв талбай бүхий 6 хүлэмжид, нийт 0.2 га талбайд тариалалт хийж 5 хүнийг ажлын байраар хангаж байна.	
2.14. Хувиараа, хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршооны гишүүн, албан бус эдийн засагт ажиллаж байгаа иргэдийн хөдөлмөрийн харилцааны суурь зарчим үндсэн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг нийгмийн түншлэлийн талууд хамтран зохион байгуулна.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ХХҮГ ХХААГ	Сумдын ЗДТГ АҮЭХ АОЭХ	Холбогдох субъектуудын хүрээнд тодорхой арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	“Шинэ хоршоо” хөдөлгөөнийг сурталчлан таниулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээлэл хүргэх, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар сумдын 620 малчин, хоршоологчдод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлснээр Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 82 хоршоо шинээр байгуулагдаж, 47 хоршооны 166 малчин 6.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож, 42 ажлын байр шинээр нэмэгдсэн. Мөн 41 хоршооны гишүүн 123 малчин өрхөд 3.1 тэрбум төгрөгийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан байна. “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнөсөөр малчид үржлийн мал худалдан авч малын сүргийн чанарыг сайжруулсан, худаг гаргах, малын хашаа хороогоо засах, шинэчилсэн, мах сүүний хөргүүртэй болсон, хадлан тэжээл бэлтгэх тоног төхөөрөмжийн хүрэлцээ нэмэгдсэн, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх нөхцөл бүрдсэн.	90%
2.15. Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Цагийн ажил” төсөл хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талууд хамтарч ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ	Сумдын ЗДТГ ГБХЗХГ АОЭХ	Холбогдох тогтоол, журмын хэрэгжилтийг хангаж, төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Хөдөлмөрийн тухай хуулинд бүтэн болон бүтэн бус цагаар ажиллуулах гэсэн хуулийн заалт байгаа ч журамласан зохицуулалт одоогоор байхгүй. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2023 онд үүнтэй холбогдуулан Улаанбаатар, Дархан-Уул, Орхон гэсэн 3 аймгаас 11 дүгээр сард судалгаа авсан. Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор “Оюутны цагаар	100%

				<p>хөдөлмөр эрхлэх журам” батлагдсан боловч 100 ба түүнээс дээш ажилтай байгууллага нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц цагийн ажлын орон тоо гаргаж, оюутныг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана гэсэн заалт аймаг, орон нутагт хэрэгжихэд хүндрэлтэй байдаг. Аймагт 100-аас дээш ажиллагсадтай 7 аж ахуйн нэгж, байгууллага байгаа судалгаа байгаа ч цагийн ажилтан авах захиалга ирдэггүй байна. Улирлын чанартай ажлуудад 2 МСҮТ-ийн оюутнууд цагийн ажилд зуучлагдаж байна. Цагийн болон сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу Орхон Политехникийн коллежоос цагийн ажлын байранд ажиллах оюутны судалгаа гаргуулан авч Bozzolo, CU, GS25, “Төгс дизайн” ХХК, Миний сүлжээ дэлгүүр, Ноён пицца, авто угаалгын газарт 9 оюутныг цагийн ажилд, 2 аж ахуй нэгж, 10 иргэний хүсэлтээр 95.5 га талбайд Орхон Политехникийн коллежийн 438 оюутныг 3-5 хоногийн хугацаатай ногоо хураалтын түр ажлын байранд тус тус зуучилсан.</p> <p>2025 онд Орхон аймгийн хэмжээнд гурван Самушил төв шинээр байгуулагдан, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлж эхэллээ. Тус төвүүд нь түр болон цагийн ажлын байранд зуучлах, анкет бүртгэх, ажлын байрны захиалга хүлээн авах зэрэг үйлчилгээг иргэдэд хүргэж байна.</p> <p>1. "Эрдэнэт Самушил" - Оюуг баг - 2025 оны 04 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, нийт 100 гаруй</p>	
--	--	--	--	--	--

				<p>иргэний анкет хүлээн авч бүртгэн, 30 иргэнийг түр болон цагийн ажилд зуучлан ажиллуулсан.</p> <p>2. Samushil HR - Эрдэнэт салбар - Булаг баг-2025 оны 05 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, 40 иргэний анкет бүртгэж, 20 иргэнийг ажилд зуучилсан.</p> <p>3. "Эрдэнэт Сайхан Уул Самушил" - Шанд баг - 2025 оны 05 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж, 60 иргэний анкет хүлээн авч, 40 иргэнийг ажилд зуучилсан.</p> <p>2025 оны эхний хагас жилийн байдлаар 200 иргэний анкет бүртгэж, 100 иргэнийг түр болон цагийн ажлын байранд амжилттай зуучлан ажиллуулсан байна. Ажилд орсон иргэдийн ажлын байрны салбараар нь авч үзвэл барилгын салбар 80 хувь, газар тариалангийн салбар 5 хувь, бусад салбарууд 15 хувийг эзэлж байна.</p> <p>Тус Самушилууд нь цаашид иргэдийг тогтворгүй хөдөлмөр эрхлэлтийн зах зээлд идэвхтэй оролцуулах, ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	
2.16. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумдын хөдөлмөр эрхлэх хүсэлтэй залуучуудыг сургалтуудад хамруулан дэмжлэг үзүүлэн ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ	Сумдын ЗДТГ ГБХЗХГ АОЭХ	Залуучуудыг оролцуулсан холбогдох сургалтуудыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран ОУХБ-ын "Бизнес эрхэлье" сургалтыг бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарын нийт 60 залуучуудыг хамруулж 2 өдөр зохион байгуулсан. Сургалтын зардалд нийт 4.8 сая төгрөгийг ХЭДСангаас зарцуулсан. "Хөдөлмөр эрхлэлт-2023" өдөрлөгийг	90%

				<p>Жаргалант суманд 2 өдөр зохион байгуулж зөвлөгөөнд оролцож буй Орхон аймгийн нийт 180 гаруй малчид, тариаланчид, Жаргалант сумын 110 иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн Ejob платформ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар танилцуулсан. 2024 онд Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран 2024 оны 1, 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн алба хааж ирсэн залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг өгч, ажил хайгчаар бүртгэж, нээлттэй зарлагдсан ажлын байрны мэдээллийг хүргэн ажилласан. Орхон Политехник коллежийг 2024 оны 1 дүгээр сард 12 мэргэжлээр төгсөж байгаа нийт 224 төгсөгчдийн дунд зохион байгуулсан “Нэг төгсөгч нэг ажлын байр” арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг танилцуулж, Ejob.gov.mn программыг сурталчлан ажил хайгчаар бүртгэсэн. Шинэ эхлэл цэг ТББ-тай гэрээлэн 45 залуучуудад 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, Шилдэг старт-ап залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 1 төсөлд 10.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд 2 ажлын байр хадгалагдаж 1 шинэ ажлын байр бий болсон байна.</p> <p>2025 ондг гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулахаар цахимаар бүртгэлийн</p>	
--	--	--	--	--	--

				<p>үйл ажиллагааг эхлүүлэн нийт 46 иргэнийг бүртгэлжүүлсэн. Бүсийн хэмжээнд Старт-ап арга хэмжээг зохион байгуулах ажлыг эхлүүлж сургалтын байгууллагын сонгон шалгаруулж “Вэст метод” ХХК-ийн дэргэдэх сургалтын төв шалгарсан. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан иргэдэд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж хурдасгуур хөтөлбөрт хамрагдах залуучуудын багийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Бүсийн хэмжээнд Старт-ап арга хэмжээг зохион байгуулах залуучуудын бүртгэлийг хойд бүсийн хэмжээнд зохион байгуулна.</p>	
2.17. Аймгийн иргэдийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой төсөл, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж 3 жилийн хугацаанд 1000-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгоно.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ НБХ ХХҮГ	Сумдын ЗДТГ	1000 шинэ ажлын байрыг бий болж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2023 онд 2266 ажлын байрны захиалга, 2024 онд 2705 ажлын байрны захиалга бүртгэгдсэн. 2024 оныг 2023 оны мөн үетэй ажлын байрны захиалга 19.4 хувиар өссөн байна. 2023 онд 1125 иргэн ажилд зуучлагдсан бол 2024 онд 1080 иргэн ажилд зуучлагдсан байна. Зуучлагдсан иргэдийг мэргэжлийн ангиллаар 2023 оны мөн үетэй харьцуулахад мэргэжилтэн 2.6 хувиар, энгийн ажил мэргэжлээр 4.5 хувиар өссөн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгээс тайлант онуудад 198 иргэнд 1306.0 мянган төгрөг олгож, 180 ажлын байр хадгалагдаж, 127 ажлын байр шинээр бий болсон байна. 2024 онд 2301 ажлын байр бий болсон нь өмнөх оноос 0.8 хувиар	100%

				өссөн бөгөөд шинээр 1104 ажлын байр бүртгэгдсэн байна. 2025 онд 805 ажлын байр бий болсны 145 нь шинэ ажлын байр байна. 2023-2025 онуудад нийт 2619 шинэ ажлын байр бий болсон байна.	
2.18. Олон улсын хөл хориот өвчний голомт, байгалийн давагдашгүй хүчин зүйл, үйлдвэрлэлийн осол, гамшгийн үед 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцгийн ажлын цагийг 2-4 цагаар хорогдуулах, эсвэл зайнаас буюу гэрээсээ ажиллах нөхцөлөөр хангаж, цалинг 100.0 хувь олгоно.	Аймгийн ЗДТГ-ын СТСХ НБХ	ХХҮГ	Холбогдох нөхцөлүүд хангагдаж, цалин 100 хувь олгогдсон байна.	Тайлант хугацаанд олон улсын хөл хориот өвчний голомт, байгалийн давагдашгүй хүчин зүйл гараагүй болно.	Үнэлэх боломжгүй
2.19. Нийтийг хамарсан цар тахалтай холбогдуулан ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудалд анхаарч, цалин орлогыг бууруулахгүйгээр ажлын байрыг хадгалах, мөн ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж зайнаас цахим орчинд ажил, үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын СТСХ	Сумдын ЗДТГ ОБГ АОК	Цар тахлын үед Ажил олгогч холбогдох зохицуулалтуудыг хийж, ажилтнууд ямар нэгэн эрсдэлгүй ажил, үүргээ гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.	Тайлант хугацаанд нийтийг хамарсан хорио цээр, цар тахал гарсан тохиолдол байхгүй болно.	Үнэлэх боломжгүй
Гурав. Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах асуудал					
3.1. Өндөр насныхаа тэтгэвэрт гарах дөхсөн хүмүүсийн нийгмийн баталгааг хангах үүднээс ажил, хөдөлмөр эрхэлж байгаа 47 ба түүнээс дээш насны ажилтнуудыг сахилгын ноцтой зөрчил гаргаснаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар ажлаас халахыг хориглоно.	АҮЭХ ҮЭ-ийн хороод	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ АОЭХ ХҮЭКОАС	Хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрийг мөрдүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Орхон аймгийн ҮЭ-ийн холбоонд энэ асуудлаар өргөдөл, гомдол ирээгүй болно.	Үнэлэх боломжгүй
3.2. Хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах талаарх хяналтыг сайжруулж, сургалт, сурталчилгаа,	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХЭЗХ ГБХЗХГ	ХХҮГ ХЭҮКОАС	Холбогдох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаанууд	2023 онд хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх зорилгоор Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ, ХХҮГ, Цагдаагийн газартай хамтран	70%

<p>нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.</p>	<p>АҮЭХ</p>		<p>зохион байгуулагдаж, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, хяналт сайжирсан байна.</p>	<p>барилга, уул уурхай, машин угаалга, хөдөө аж ахуй, боловсруулах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 38 аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн үзлэг, хяналт шалгалтыг зохион байгуулж, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт, зөвлөмжийг хүргэн ажилласан байна. Хяналт шалгалтын үр дүнд дээрх салбаруудад хөдөлмөр эрхэлж буй хүүхэд тогтоогдоогүй. Харин “Монпити ойл” ХХК-д насанд хүрээгүй хүүхэд ажиллаж байна гэсэн иргэний гомдлын дагуу шалгалт хийж, 2 хүүхдийн нөхцөл байдлыг үнэлэн, эцэг эхэд зөвлөгөө өгч, хүүхдүүдийг сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, холбогдох байгууллагуудад албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан байна. 2024 онд хөдөлмөрийн үзлэг, шалгалтыг өргөжүүлэн зохион байгуулж, барилга, уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 45 аж ахуйн нэгжийг хамруулсан. Шалгалтаар хөдөлмөр эрхэлж буй 1 хүүхдийг илрүүлж, тухайн байгууллагад албан шаардлага хүргүүлэн зөрчлийг арилгуулсан байна. Мөн цахимаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлж, хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийн талаарх постер, зөвлөмжийг Erdenet.mn болон албан</p>	
--	-------------	--	--	--	--

				<p>ёсны цахим хуудсаар түгээж, 5040 хүн хандсан байна. Түүнчлэн аймгийн Засаг даргын А/79 дүгээр захирамжийг гаргуулан хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг хориглож, хэрэгжилтэд нь хяналт тавьсны үр дүнд тухайн онд ямар нэгэн зөрчил гараагүй.</p> <p>2025 оны эхний хагас жилийн байдлаар уралдаанч хүүхдийн амьнас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор дөрвөн төрлийн арга хэмжээг зохион байгуулж, тухайн хугацаанд болсон 2 удаагийн хурдан морины уралдаанд хяналт тавьж ажилласан. Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг хориглосон аймгийн Засаг даргын А/765 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумдын Засаг дарга, морин спортын холбоодод зөвлөмж хүргүүлж, олон нийтэд чиглэсэн гурван төрлийн постер, сэрэмжлүүлгийг цахим орчинд түгээсэн. “Ирээдүйн хурд–2025” уралдаан долоон насны ангиллаар зохион байгуулагдаж, нийт 232 морь уралдсан бөгөөд 107 уралдаанч хүүхэд оролцсон байна. Уралдааны үеэр 6 хүүхэд мориноос унаж, 5 нь хөнгөн бэртэл авсан бол 1 хүүхэд гэмтэл аваагүй байна.</p> <p>2023–2025 оны хугацаанд хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо 38-аас 45 болж 7-оор өссөн, хүүхдийн хөдөлмөр илрүүлэлт буурсан үзүүлэлттэй гарч, мэдээлэл,</p>	
--	--	--	--	--	--

				сурталчилгаа, олон нийтэд чиглэсэн ажлын цар хүрээ өргөжсөн байна. Хурдан морины уралдаанд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль, захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмолжуулснаар 2023 онд зөрчилгүй, 2024 онд хориглолтын хэрэгжилт бүрэн хангагдсан, 2025 онд уралдаан зохион байгуулагдсан ч хяналт, урьдчилан сэргийлэх ажил эрчимжсэнээр хүүхдийн амь нас, эрүүл мэндийг ноцтой эрсдэлээс хамгаалж чадсан үр дүнтэй байна.	
3.3. Хууль тогтоомжид өөрчлөлт орсны дагуу Төрийн өмчит үйлдвэр, хувьцаат компанийг хувьчлахдаа хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжиж болох бөгөөд тухайн үйлдвэр, компанийн ажилтнуудад эзэмшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ХЭЗХ ОНӨГ	-	Ажилтнуудад тодорхой хэмжээний хувьцаа эзэмшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар тухайн холбогдох байгууллагуудын удирдлагууд болон нийгмийн түншлэлийн талууд идэвх санаачилга гаргаж, бүх талын нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хууль Улсын Их Хурлаар батлагдсаны дараа Төрийн өмчит үйлдвэр, хувьцаат компанийг хувьчлах асуудлыг хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжих, компанийн ажилтнуудад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	Үнэлэх боломжгүй
3.4. Төрийн үйлчилгээний байгууллагын хэвийн үйл ажиллагаа ханган ажилладаг /ТҮ1-ТҮ3/ ажилтнуудыг хувийн хэвшилд шилжүүлэхгүйгээр ажлын байрны баталгаа, цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлүүлэхэд талууд хамтран ажиллана.	АҮЭХ АОЭХ	Аймгийн ЗДТГ-ын СТСХ	Ямар нэгэн маргаан, зөрчилгүйгээр хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Уг асуудлаар өргөдөл, гомдол гараагүй байна.	Үнэлэх боломжгүй
3.5. Төрийн болон хувийн хэвшлийн	Аймгийн ЗДТГ-	АҮЭХ	Сургалт зохион	Аймгийн Засаг даргын Тамгын газрын	100%

<p>хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар нийгмийн түншлэлийн талууд хамтарч сургалт зохион байгуулна.</p>	<p>ын ХЭЗХ</p>	<p>АОЭХ</p>	<p>байгуулагдаж, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>Хууль, эрх зүйн хэлтэс, Хүний эрхийн Үндэсний комиссын референт, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчтэй хамтран БОГ, ХХААГ, МЭГ, ХХҮГ зэрэг төрийн 7 байгууллагын 173 албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 327 багш, ажилчин, “Эрдмийт” ХХК, “Хөх ган” ХХК зэрэг хувийн хэвшлийн 117 ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Мөн хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж 2024 оны 05 дугаар сарын 02-21-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн нийт 92 байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын хүрээнд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд хяналтын камер байрлуулсан байдал болон хурууны хээний бүртгэл үйлчилгээ, ажилчдын цаг бүртгэл радио давтамжийн эрхийн бичиг зэргийг газар дээр нь шалгаж илэрсэн зөрчил дутагдал дээр тухай бүр нь заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны ҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан “Нийтийн аж ахуйн салбар дахь ажлын байрны дарамт, хүчирхийллийн нөхцөл байдал”</p>	
---	----------------	-------------	--	--	--

				<p>судалгааны танилцуулга сургалтад ҮЭХ-ны ажилтан цахимаар оролцсон бөгөөд тус холбооны дарга Б.Жавзандулам Орхон аймагт ажиллаж Хот тохижуулах газрын 58, “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-ийн 75, “Сууц өмчлөгчдийн холбоо”-ны 21 ажилтнуудыг тус судалгаанд хамрууллаа.</p> <p>ҮНҮЭ-ийн хороодод Зөвлөн туслах-Хяналт шалгалт хийх ажлын хүрээнд ҮЭ-ийн гишүүдэд хууль, эрх зүйн мэдлэг олгох тараах материалыг “Ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох” сэдвээр бэлтгэн хүргэсэн. Мөн Политехник коллежийн захиргааны хүсэлтийн дагуу “Хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, тус сургалтад 45 хүн хамрагдсан байна. Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран 2025 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг таниулах” үйл ажиллагааны талаар сургалт хэлэлцүүлгийг 2 өдөр зохион байгуулсан. Тус сургалт хэлэлцүүлгээр хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ЕБС-ийн 250 сурагч, Их дээд сургууль, коллежийн 28 оюутан, 110 иргэн, захиргааны байгууллагын 34 төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэгтэй 26 албан</p>
--	--	--	--	---

				хаагч, ТББ-ын төлөөлөл болон үйлдвэрчний эвлэлийн хорооны 40 гишүүд нийт 448 хүн хамрагдсан байна.	
3.6. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх хуулиар үүссэн 65-с доош насны ажилтан өөрөө хүсэлт гаргаагүй тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар ажлаас халахыг хориглоно.	АҮЭХ ҮЭ-ийн хороод	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ АОЭХ ХҮЭКОАС	Холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Энэ асуудлаар өргөдөл, гомдол ирээгүй болно.	Үнэлэх боломжгүй

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал

4.1. Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг жил бүр аймгийн төсөвт суулган баталж, зориулалтын дагуу зарцуулж, үйл ажиллагааны тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үр дүнг тооцож ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ХХҮГ	НДГ АҮЭХ АОЭХ	Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна	2023 онд "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд 10.0 сая төгрөг, аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн зардалд 10.0 сая төгрөг, нийт 20.0 сая төгрөг орон нутгийн төсвөөс төсөвлөсөн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сургалт, уулзалт, зөвлөгөөн, хурал, холбогдох байгууллагуудаас санал авах дээд шатны байгууллагуудад хүргүүлэх, видео бичлэг хийх зэрэг 18 ажлыг төлөвлөн бүрэн гүйцэтгэсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сарын аян, сургалт, улсын үзлэг зохион байгуулах, уулзалт хэлэлцүүлэг хийх, туршлага түгээн дэлгэрүүлэх зэрэг 9 ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй хийсэн.	100%
				Орхон аймгийн Засаг даргын 2024	

				<p>оны А/159 дүгээр захирамжаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2024 онд хийх ажлын төлөвлөгөөний хүрээнд 4 ажил зохион байгуулахаар 10.0 сая төгрөг, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 5 зорилт 25 арга хэмжээ зохион байгуулахаар 5.0 сая төгрөг тус тус баталсныг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:</p> <p>Сарын аяныг “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээ” уриан дор зохион байгуулж, 2 төрлийн зөвлөмж, малчдад зориулсан гарын авлага, Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг хүндэтгэх зул өргөх үйл ажиллагаа, халуунаас үүдэлтэй стресс, бухимдлаас урьдчилан сэргийлэх баннер зэргийг хийж бэлтгэн нийгмийн түншлэлийн 3 талын цахим хуудас болон hab.erdnet.mn веб сайт, ETV телевиз, цахим орчинд түгээсэн. Бэлтгэсэн зөвлөмжийг сургалтад хамрагдсан иргэд болон томоохон худалдааны төв, 30 гаруй байгууллагын 10000 гаруй ажилтан албан хаагч нарт хүргэсэн. Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ХАБЭА-н ерөнхий ойлголт, ХАБЭА-н тухай хууль, Асбестын хор нөлөө, Эрсдэлийн үнэлгээний арга зүй сэдвүүдээр 5 байгууллагын 206</p>	
--	--	--	--	--	--

				<p>ажилтан албан хаагчдад 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>“Эрсдэлийн үнэлгээний арга зүй, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ҮОХХСБК, ХАБЭА-н зөвлөлийн гишүүд дарга нарт үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюулт хүчин зүйлс урьдчилан сэргийлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын зохион байгуулалт, ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн байдал сэдэвт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 200 аж ахуй нэгж, байгууллагын 220 гаруй албан ажилтан албан хаагчид хамрагдсан.</p> <p>2025 онд нийт 8 ажил зохион зохион байгуулж “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил, хиймэл оюуны хэрэглээ ба цахимжилт” уриан дор явагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зөвлөгөө, мэдээлэл, постер, шторк зэрэг 17 төрлийн үйл ажиллагаа, 4 удаагийн сургалт, 1 спортын арга хэмжээг зохион байгуулсан. Орхон аймгийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудад 6 удаагийн хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж 350 гаруй албан хаагчдыг хамруулаад байна.</p>	
<p>4.2. ХАБЭА-н болон Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх хамтарсан үзлэг, шалгалтыг жил бүр нийгмийн түншлэлийн талуудын оролцоотой хийнэ. Холбогдох зардлыг аймгийн төсөвт суулган баталж,</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ ХЭЗХ АҮЭХ</p>	<p>АОЭХ ШӨХТГ</p>	<p>Хамтарсан үзлэг, шалгалт хийгдэх, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03/826 дугаартай улсын үзлэг явуулах тухай албан бичиг, ХНХЯ-ын баталсан удирдамж, Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/351 дугаартай захирамжаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж хэрхэн</p>	<p>100%</p>

зориулалтын дагуу зарцуулж, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үр дүнг тооцож ажиллана.

хэрэгжиж байгаатай газар дээр нь танилцах, судалгаа хийх, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр үзлэг шалгалт хийгдсэн. Үзлэгийг Нийгмийн түншлэлийн талууд бүхий аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүд болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн аймгийн үзлэгийг боловсролын салбарын 36 аж ахуйн нэгж, байгууллагын 2129 ажилтныг хамруулан зохион байгууллаа. Эдгээрээс 25 аж ахуйн нэгж, байгууллагад Хөгжлийн бэрхшээлтэй 57 иргэн мөн 3 байгууллагын 8 ажилтан хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байна. Хуулийн хэрэгжилтийн үзлэгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 68.5, Хөдөлмөрийн тухай хууль 78 хувьтай байна. Хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад үзлэг, шалгалтын явцад өгсөн зөвлөгөөний дагуу илэрсэн зөрчлийг арилган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал хүргэсэн. Мөн Орхон аймагт Мэргэжлийн боловсрол сургалтын үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгж, байгууллагын 299 ажилтныг хамруулан улсын үзлэг зохион байгууллаа. Эдгээрээс 3 аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэн мөн

				<p>хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг хүн байхгүй байна. Улсын үзлэгт хамрагдсан МСҮТ-үүдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтын үзүүлэлт 87.5 хувь, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын үзүүлэлт 84.3 хувь, ажлын орчин, ахуйн байрны эрүүл ахуйн нөхцөлийн үзүүлэлт 75.7 хувьтай, дундаж нь 82.4 хувьтай байна.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан хэмжээгээр төсөвт тусгах албан бичгийг төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар зэрэг 73 байгууллагад хүргүүлсэн.</p> <p>2024 онд хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын 3 байцаагч хөдөлмөрийн хяналтаар 26, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар 15, нийт 41 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөвтөө суулгаж байх талаар зөвлөгөө мэдээлэл, чиглэлийг аж ахуйн нэгж, байгууллагад өгч ажилласан.</p> <p>2024 онд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг Орхон аймагт үйл</p>	
--	--	--	--	--	--

				<p>ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэр харгалзахгүй 36 байгууллагаар хийсэн. Удирдамжид тусгагдсаны дагуу үйлдвэрлэлийн осол гарсан байгууллага, хөдөлмөрийн эрхийн маргаан гарсан 32 аж ахуйн нэгж, байгууллагын 10495 ажилтныг хамруулан зохион байгуулсан. Хуулийн хэрэгжилтийн үзлэгээр Хөдөлмөрийн тухай хууль 75 хувь, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтын үзүүлэлт 79 хувь, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын үзүүлэлт 80 хувь, ажлын орчин, ахуйн байрны эрүүл ахуйн нөхцөлийн үзүүлэлт 85 хувьтай, дундаж нь 79.8 хувьтай байна.</p> <p>2023, 2024 оны үзлэгийн үйл ажиллагааны зардалд ХАБЭА-н зөвлөлийн зардлаас нийт 4.0 сая төгрөг зарцуулсан. Үзлэгийн дүнг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох яаманд тайлан, дүгнэлтийг хүргүүлсэн.</p> <p>2025 онд Хөдөлмөр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар 35 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар нийт 496 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 89 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн хамтарсан 344 заалттай 32 албан шаардлага хүргүүлсэн. 4 аж ахуйн нэгж, байгууллагад ээлжийн амралтын цалин, шөнийн болон илүү цагийн нэмэгдэл хөлс, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны нөхөн төлбөр болох 38.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийн</p>	
--	--	--	--	---	--

				<p>акт тогтоосон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт 73.7 хувь, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт 77.7 хувьтай тус тус хэрэгжиж байна. Хөдөлмөрийн харилцааны хяналтын хуудсаар шалгахад 2 нь их, 5 нь дунд, 17 нь бага, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын хуудсаар шалгахад 8 нь их, 8 нь дунд, 8 нь бага, Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудсаар шалгахад 3 нь бага, 3 нь дунд, 5 нь их эрсдэлтэй үнэлэгдлээ.</p> <p>Хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах хуулийн хэрэгжилтийн талаар улсын үзлэг зохион байгуулагдаж байгаа бөгөөд 2025 онд нийт төрийн болон хувийн хэвшлийн 172 байгууллагад судалгаа хүргүүлснээс судалгаа ирүүлсэн 69 байгууллагад 9318 хүн ажиллаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 141 иргэн ажиллаж байна. Ажиллавал зохих 26 байгууллагын 231 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй байна. Тус байгууллагуудад үзлэг шалгалт хийж холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.</p>	
<p>4.3. Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэдэг орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ Сумдын ЗДТГ ХХҮГ АҮЭХ АОЭХ</p>	<p>Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн үйлдвэрлэл нэмэгдэж, чанар дээшилсэн байна.</p>	<p>Германы хамтын ажиллагааны GIZ төслөөс 2022 онд үйлдвэрлэлийн хортой нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл үйлдвэрлэдэг “Беко” ХХК-д 8.8 сая төгрөг, ажлын хувцас үйлдвэрлэдэг “Саран үйлс” ХХК-д 4.0 сая төгрөг, “Мөнх баян алт” ХХК-д 9.1 сая төгрөг, үйлдвэрийн хор саармагжуулах</p>	<p>70%</p>

				<p>бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Ачит Андага” ХХК-д 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. 2025 оны 09 дүгээр сард Налайх дүүргийн Тайж хайрхны бэлд зохион байгуулагдсан “Уул уурхайн 7 хоног” арга хэмжээнд “Ачит андага” ХХК-ийг дэмжин оролцуулснаар тус газар нь уул уурхайн үйлдвэрүүдэд хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэх талаар хамтын ажиллагаа үүсгэхээр холбоо тогтоосон. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, “Ора металл” ХХК зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд “Уран хас” ХХК, “Гутал буян” ХХК зэргээс ажилчдын ажлын хувцас, ажлын гутал худалдан авч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж байна.</p>	
<p>4.4. Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт ажиллаж буй худалдааны зах, барилга барьсан компаниудын зөвшөөрлийг олгохдоо гаргасан зураг төслийн дагуу гаднах орчны тохижилт хийлгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж, гарах нөхцөл, аюулгүй байдлыг бүрдүүлэх шаардлага тавьж хэрэгжилтийг хангуулна.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ НБХ ХЗА ГХБХБГ</p>	<p>ХХҮГ ХББЗА</p>	<p>Хэрэгжилтийг хангаж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ямар нэгэн эрсдэл, аюулгүй зорчих, үйлчлүүлэх нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, хөгжлийн бэрхшээлтэй төдийгүй нийт иргэдэд ээлтэй дэд бүтэц, барилга, байгууламж, зам, гарцыг нэмэгдүүлэх, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулан, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа сайжруулах зорилгоор “Тэгш боломж, хүртээмжтэй” орчин аяныг 1 жилийн хугацаатай зарласныг 2023 онд дүгнэж 1 дүгээр байранд БОЭТ орж 1.5 сая төгрөг, 2 дугаар байранд Эрдэнэтийн ДЦС орж 1.0 сая төгрөг, 3 дугаар байранд 27 дугаар цэцэрлэг орж 500.0 мянган төгрөгөөр тус тус шагнагдсан. Төрийн бүх шатны нийт 117 байгууллагыг хамруулан MNS 6055:2009 стандартын хүрээнд</p>	<p>100%</p>

				<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын баталсан 9 үзүүлэлтийн 33 асуумжтай үнэлгээний хуудсаар үнэлгээг хийсэн. Судалгаа, үнэлгээнд нийт 117 байгууллага хамрагдсан ба нийтлэг гэж үзсэн 9 объектод /налуу зам, орох гарах хаалга, ариун цэврийн байгууламж гм/ 33 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийхэд стандартын шаардлагыг 100 хувь хангасан байгууллага байхгүй. Ажлын хэсэг байгууллага тус бүр дээр дүгнэлт гарган стандартыг дахин хүргүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл бүхий Засаг даргын албан даалгаврыг хүргүүлж ажиллах мөн дэд бүтцийн хүртээмжийн талаар сурталчилсан ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Шинээр баригдаж ашиглалтад өгч буй барилга байгууламжийг хүлээн авах улсын комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг ажиллуулж байна. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс аймгийн Засаг даргын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн ажил зохион байгуулах тухай” А/228 дугаар захирамжийг гаргаж бүх байгууллагуудад хэрэгжүүлж ажиллах чиглэл хүргүүлсэн. Захирамжийн гол агуулга нь төр, хувийн хэвшил, худалдааны байгууллагууд гаднах орчноосоо</p>
--	--	--	--	--

			<p>эхлээд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчныг бүрдүүлэх, тэднийг тохирсон ажлын байраар хангах, бүхий л байгууллага тэргүүн ээлжинд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилдэг байх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний гадна хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд үлдээхгүй байхад анхаарах юм.</p> <p>2024 онд явган замын эвдрэлтэй хэсгүүдэд үзлэг хийн засварлах шаардлагатай явган замын судалгааг гарган, 756м2 явган замыг шинэ хавтангаар нөхөж, 160 м2 замыг хуучин хавтангаар нөхөлт хийгдсэн. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 8 багийн нутаг дэвсгэрт нийт 5019м2 явган хүний замын засвар шинэчлэлт хийгдсэн. ГХБХБГ-аас 9 барилга байгууламж шинээр ашиглалтад оруулж хүлээн авсан ба орон сууцны 5 барилга дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулан хүлээн авсан. Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай хийсэн гэрээнд заагдсаны дагуу нийтийн зориулалттай барилга, байгууламжид хүртээмжийн үнэлгээг ГХБХБГ, ХЗА, ХББЗА, Баян-Өндөр сум, Жаргалант сумаас бүрэлдэхүүн томилогдон бүх хороололд нэгдсэн үзлэгийн хуудсаар үзлэг зохион байгуулсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан 15 ширхэг 40-45 хүний багтаамжтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн дунд оврын автобусыг худалдан авч иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэж</p>	
--	--	--	---	--

				байна. 2024 онд орон нутгийн төсвийн 8.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 698м урт асфальт бетон хучилттай авто зам, замын байгууламж, 11 багийн 14 байршил 5.8 км авто замд их засвар шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулсан. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12 багт 804 гэрэлтүүлэг шинээр төлөвлөж, Баян-овоот, Яргуйт, Их залуу, Чингэл, Эрдэнэ, Баянбулаг, Говил, Даваат, Дэнж, Рашаант, Уртын гол, Шанд, Эрдэнэ, Уурхайчин, Баянцагаан, Наран, Хүрэнбулаг багуудад нийт 896 гэрэлтүүлгийг шинээр хийн гүйцэтгэж 2024 оны өссөн дүнгээр Эрдэнэт хот 11628 гэрэлтүүлэгтэй болсон байна.	
4.5. Нийтийг хамарсан хорио цээр, гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн болон хүчний байгууллагын ажилтнуудын хамгаалах хэрэгсэл, ажлын цагийн зохицуулалтыг хийхэд онцгойлон анхаарч илүү цагийн хөлсийг тухай бүрд нь орон нутгийн төсвөөс гаргаж, гүйцэтгэлд нь нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.	Аймгийн ЗДТГ-ын СТСХ НБХ ОБГ ЭМГ ЦГ	АҮЭХ АОЭХ	Хяналт сайжирч, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	2023 онд орон нутгийн төсвөөс Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамгаалах хувцас хэрэгсэлд 2.7 сая төгрөг, Ковид-19 өвчний оношлуурын зардалд 25.0 сая, илүү цагийн цалингийн зардалд 9.1 сая төгрөг, ЭМГ-аас илүү цагийн цалингийн зардалд 3.5 сая төгрөгийг тус тус шийдвэрлэж олгосон байна. 2024 онд томуу, томуу төст өвчин, илүү цагийн цалингийн зардалд ЭМГ-аас 32.4 сая төгрөгийг олгосон. 2025 онд улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээнд илүү цагийн цалин хөлсний зардалд 9.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон байна.	100%
4.6. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж,	Аймгийн ЗДТГ-ын НБХ НДГ	ЭМГ АҮЭХ АОЭХ	Сургалт зохион байгуулагдаж, хууль тогтоомжийн	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/56 дугаар “Аймаг, дүүргүүдэд зохион байгуулах	100%

<p>төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад аймгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан зохион байгуулж, хэрэгжилтэд нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.</p>	<p>ХАБЭАЗ</p>		<p>хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>сургалтын төсвийн хуваарь батлах тухай” тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 01/916 дугаар “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны А/15 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан. Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н шинэчлэгдсэн хууль, дүрэм журам, ХАБЭА-н зөвлөлийн ажил чиглэл, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрэм, ажлын байрны аюулгүй ажиллагаа, ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөмж, эрсдэл тооцох индикатор, ҮОМШӨ-ий даатгалын сан зэрэг сэдвүүдийн хүрээнд сонгон шалгаруулалтаар шалгарсан “Эндээ хөгжил” ТББ нь 2023 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх ХАБЭА-н сургалтыг аж ахуйн нэгж, байгууллагуудын ХАБЭА хариуцсан ажилтан болон удирдлагуудад 4 цагийн сургалт, нийт ажилтнуудад 2 цагийн сургалт орсон ба төсөвт байгууллага болон ХАБЭА-н мэргэшсэн ажилтны сургалтад 79 хүн, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, ЗДТГ-ын ажилтан албан хаагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид гэсэн нийт 65 хүн, Хот тохижуулах газрын 100 ажилтан албан хаагчид сургалтад хамрагдлаа.</p> <p>2024 онд тайлант хугацаанд хөдөлмөрийн чадвар алдсан болон тэжээгчээ алдсан 332 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 3.9 тэрбум төгрөг,</p>	
---	---------------	--	------------------------------------	---	--

				<p>хөдөлмөрийн чадвар түр алдсан 23 иргэний тэтгэмжид 61.1 сая төгрөг, хиймэл эрхтэн, протез зардал 1 даатгуулагчид, нөхөн сэргээх зардалд 277 даатгуулагчид 288.1 сая төгрөгийн зардал тус тус зарцуулсан байна.</p> <p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалтыг үндэслэн 83 гаруй даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгосон.</p> <p>2025 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон тэжээгчээ алдсан 279 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 1.6 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 38 иргэний тэтгэмжид 46.4 сая төгрөг, хиймэл эрхтэн, протез олгогдоогүй, нөхөн сэргээх зардалд 459 даатгуулагчид 116.5 сая төгрөгийн зардал тус тус зарцуулсан байна. 2025 оны 10 дугаар сард сургалт, нөлөөллийн ажил контент байгуулахаар төлөвлөж байна.</p>	
<p>4.7. Эрдэнэт хотын утаа, агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улиралд утааг арилгах гэр хорооллын өрх бүрийг 2 тарифт цахилгааны тоолуураар хангах ажлыг дэмжиж, халаалт, дулааны асуудлаа цахилгаанаар шийдэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг эрх бүхий холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ БОГ ХЗА</p>	<p>Сумдын ЗДТГ</p>	<p>Утаа, агаарын бохирдлыг багасгаж, иргэд, оршин суугчдын ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлээр 13614 айл өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 28 уурын зуух, 24398 авто тээврийн хэрэгсэл байна. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц /ЧИП/-ыг олгож яндангийн тоог 182 ширхгээр бууруулсан. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 2024 онд “Хабрид хаус” ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар</p>	<p>50%</p>

				<p>бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. Мөн гэр, байшингийн халаалтын эх үүсвэрийг өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалтаар шийдвэрлэж, яндангаа буулгасан 184 өрх нэмэгдсэнээр өссөн дүнгээр 379 өрх эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлээд байна.</p> <p>Эрдэнэт хотын утаа, агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд дэлхийн банкны төслийн хүрээнд баригдсан 0.4 кВ-ын ЦДАШ, ухаалаг тоолуурт шилжүүлэх ажлыг 2024 оны 10 дугаар сараас эхлэн одоогийн байдлаар нийт 14484 хэрэглэгч холбохоос 5503 хэрэглэгчийг холбоод байна. Үүнд: Яргуйт багийн 757, Даваат багийн 195, Баян-Овоот багийн 647, Говил багийн 332, Их залуу багийн 520, Чингэл багийн 141, Дэнж багийн 703, Эрдэнэ багийн 617, Наран багийн 435, Хабитат хэсэг 126, Шанд багийн 200, Рашаант багийн 281, Уртын гол багийн 198, Цагаанчулуут багийн 200, Даваат хөтөл хэсэг 52, Баянбулаг багийн 99 хэрэглэгчид холбогдсон байна. Уг хэрэглэгчдийг төслийн шугамд холбосноор өвлийн улирал, оргил ачааллын үед хүчдэлийн хэвийн түвшинд байх ба хэрэглэгч халаалт дулаанаа цахилгаанаар хангах нөхцөл бүрдэнэ.</p>	
4.8. Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын гэрээний биелэлт, аймгийн гурван талт хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийн	Аймгийн ЗДТГ-ын НБХ АҮЭХ АОЭХ ХАБЭАЗ	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ХХҮГ	Хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажилласан	Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хороо 18 аж ахуй нэгж, байгууллагаас 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ хэлэлцээрийг батлуулж	90%

<p>байдал, ХАБЭА-н орчныг сайжруулахад эко технологи, цэвэр хөгжлийн механизмыг нэвтрүүлсэн талаар хийгдсэн ажлыг тухайн оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэж 10 хүртэлх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагыг шилдгээр шалгаруулж, аймгийн Засаг дарга, ҮЭ-ийн холбоо, Ажил олгогч эздийн холбооны хамтарсан шагналаар шагнаж урамшуулна.</p>			<p>шилдэг тэргүүний үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулж алдаршуулна.</p>	<p>бүртгүүлэхээр хүсэлт ирүүлснийг Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх заалтын дагуу бүртгэсэн. ХАБЭА-н шилдэг шалгаруулах үйл ажиллагааг явуулж 2023 онд Эрдэнэт Булганы ЦТС ТӨХК, Ачит ихт ХХК, 5 дугаар цэцэрлэг, Дэгдээхэй цэцэрлэг, 5 сургууль гэсэн 5 байгууллагыг алдаршуулсан.</p> <p>2024 онд 4 дүгээр сургууль, Эрдэнэт Булганы ЦТС, Эрдэнэт ус ДТС ОНӨК, 14 дүгээр сургууль, 4 дүгээр цэцэрлэг зэрэг 5 байгууллага шалгарсан.</p> <p>2025 оны байгууллагууд шалгарах хугацаа болоогүй.</p>	
<p>4.9. Аймгийн нийт аж ахуйн нэгж, байгууллагуудад ХАБЭА-н бүтцийг, нормативын дагуу ажиллуулахад нийгмийн түншлэлийн талууд хамтран хяналт тавьж ажиллана.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ АОЭХ АҮЭХ</p>	<p>-</p>	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 15.8, Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хороог нийгмийн түншлэгч талуудын бүрэлдэхүүнтэйгээр Засаг даргын захирамжаар байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, ХАБЭА-н салбар зөвлөлийн хуралдаанууд тогтмолжсон. Зөвлөл тус бүрд нийгмийн түншлэгч талууд оролцоог жигд ханган ажиллаж байна.</p>	<p>100%</p>
<p>4.10. Жил бүрийн 4 дүгээр сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар болгон тэмдэглэж, 4 дүгээр сарын 28-ны өдөр буюу “Үйлдвэрлэлийн ослоор амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” үйлдвэрлэлийн ослоор амь үрэгдэгсдийн ар гэрт хүндэтгэл</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын НБХ</p>	<p>АОЭХ АҮЭХ</p>	<p>Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.</p>	<p>Орхон аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс жил бүрийн 04 дүгээр сард зохион байгуулагддаг ХАБЭА-н сарын аяны хүрээнд 04 дүгээр сарын 28-ны өдөр үйлдвэрлэлийн ослоор амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх үүднээс Орхон аймагт үйл</p>	<p>100%</p>

<p>үзүүлэх арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагууд зохион байгуулна.</p>				<p>ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд оролцож, өөр өөрийн албан байгууллага дээрээ 1 минут хүндэтгэл үзүүлж дуугүй зогсох, ганданд Үйлдвэрлэлийн осолд амь үрэгдэгсдийн хойдын буянд зориулан багц ном, “Оройн ерөөл”, “Алтан ганжуур” зэрэг ном айлтгуулан, 108 зул өргөдөг бөгөөд үүнд нийгмийн түншлэлийн талууд идэвхтэй оролцдог.</p>	
<p>4.11. Аймагт Хог ангилан ялгах үйлдвэр байгуулагдаж байгаатай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагуудаас гаргасан санал, санаачилгыг дэмжиж “Хог хаягдлаа ангилан ялгаж, орчны бохирдлыг бууруулах, байгаль орчноо хайрлан хамгаалах” хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн сэтгэл зүй, хандлагыг өөрчилнө.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ХЗА ХТГ</p>	<p>Сумдын ЗДТГ</p>	<p>Аймагт Хог ангилан ялгах үйлдвэр байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, нийгмийн сэтгэл зүй, хандлагыг өөрчлөгдсөн байна.</p>	<p>Хог хаягдлын менежментийг бүх нийтэд сурталчлах зорилгоор “Хог бол баялаг” сэдэвт өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгийн хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах сургалтыг зохион байгуулж, ЕБС-ийн эко клубийн сурагчид дахин ашиглах боломжтой хуванцар савны тэмдэг болон хог хаягдлаар бүтээл хийх, хаягдал цаасаар шахмал түлш, гал асаагуур хийх талаар, иргэн н.Должинсүрэн хаягдал өөх тосоор саван хийх талаар, мөн өөрт хэрэгцээгүй хувцас, эд хэрэглэлээ хэрэгтэй хувцсаар солих үйл ажиллагааг тус тус зохион байгуулж өдөрлөгт нийт 34 байгууллага, 281 иргэн оролцож, 1тн 50кг өөх тос, 250кг хаягдал цаас, 50кг хуучин хувцсыг байгальд хаягдахаас сэргийлсэн. ЕБ-ын 2, 3, 4, 8, 13, 14, 15-р сургуулиуд “Хог хаягдлаа ангилан ялгаж хэвшье” сургалтыг ахлах ангийн нийт 300 сурагчдад, “Цэвэр сургууль” аяныг бага ангийн хүүхдүүдэд нөлөөлөх зорилгоор зохион байгуулж нийт 10456 иргэнд</p>	<p>100%</p>

				<p>мэдээлэл хүргэн ажилласан байна. Хог хаягдлын менежментийг бүх нийтэд сурталчлах зорилгоор “Хог бол баялаг” сэдэвт өдөрлөг зохион байгуулж өдөрлөгийн хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах сургалтыг зохион байгуулж, ЕБС-ийн эко клубийн сурагчид дахин ашиглах боломжтой хуванцар савны тэмдэг болон хог хаягдлаар бүтээл хийх, хаягдал цаасаар шахмал түлш, гал асаагуур хийх талаар, иргэн н.Должинсүрэн хаягдал өөх тосоор саван хийх талаар, мөн өөрт хэрэгцээгүй хувцас, эд хэрэглэлээ хэрэгтэй хувцсаар солих үйл ажиллагааг тус тус зохион байгууллаа. Хог хаягдлын менежментийг сайжруулах соён гэгээрүүлэх нөлөөллийн сургалтыг 7 ментор сургагч багш нар мэдлэг олгох зорилгоор 2-р сургуулийн 1-12 ангийн 480 хүүхдүүдийг мөн 30 багш ажилтан албан хаагчдыг хамруулж хог хаягдлын талаарх мэдлэг ойлголтыг өгч ажилласан.</p> <p>2023-2024 оны хичээлийн жилд олон улсын "Эко сургууль, цэцэрлэг" - I, II хөтөлбөрт СӨБ байгууллага 4 (11, 22, 24, Бялзуухай цэцэрлэг) 7 Ерөнхий боловсролын сургууль (4, 5, 14, 15, 13, 20, Орхон-Эмпати сургууль) 1 политехникийн коллеж, нийт 12 байгууллага 1, 2 дугаар шатны сургалтад хамрагдаж батламж авсан.</p> <p>Хот тохижуулах газрын санал хүсэлт авах 77145454 утсанд иргэдээс ирсэн 97 санал хүсэлтэд хариу мэдээлэл өгч ажиллав. Баян-Өндөр сум, багууд</p>	
--	--	--	--	---	--

				<p>хөршийн холбоо, гудамжны ахлагч нарыг чадавхжуулах тэднээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд нийт 50 иргэнийг сургалт мэдээлэл өгөх зорилгоор сургалтад хамруулсны үр дүнд 10599 иргэнд хог хаягдлыг ангилан ялгах талаар мэдээлэл хүргээд байна.</p> <p>Баян-Өндөр сумын тамгын газрын фэйж хуудас болон багуудын фэйж хуудсуудад хог ангилан ялгах, хогоо хогийн саванд хийж хэвших дадал зуршил олгох мэдээллүүдийг 56 удаа байршуулж давхардсан тоогоор 35485 иргэнд мэдээлэл хүргээд байна.</p> <p>Хот тохижуулах газар иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудсаар үйл ажиллагаа болон хог хаягдлын чиглэлээр мэдээллүүдийг видео болон зурган хэлбэрээр нийтэлж ажилладаг. Нийт 414 нийтлэл, иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд 4 контент, 17 шторк, 85 видео бэлтгэж нийтлэн ажилласан. Нийт мэдээллийг давхардсан тоогоор 68000 хандалтай байна.</p>	
--	--	--	--	---	--

Тав. Нийгмийн хамгааллын асуудал

5.1. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд инфляцын түвшин, салбарын онцлог байдал, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар Ажил олгогч эздийн болон Үйлдвэрчний эвлэлийн холбооны саналыг тусган холбогдох дээд шатны байгууллагад	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ СТСХ	АҮЭХ АОЭХ ҮЭ-ийн хороод	Төрийн захиргааны холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, тухайн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлүүлсэн байна.	Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх Засгийн газрын шийдвэрийн дагуу цалин хөлс, тэтгэмжтэй холбоотой нэмэгдлийг төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын цалин хөлсний нэмэгдлийн асуудлаар Ажил олгогч эздийн болон Үйлдвэрчний эвлэлийн холбооны саналыг тусган	100%
---	-----------------------------	-------------------------	---	---	------

уламжилж хамтарч ажиллана.				холбогдох дээд шатны байгууллагад уламжилж хамтарч ажиллахад бэлэн байна.	
5.2. Төрийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлттэй уялдуулан хувийн хэвшлийн үйлдвэр, ААНБ-д, төрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компаниуд, улсын үйлдвэрийн газрууд ажилтнуудынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг хамтын гэрээ, хэлэлцээртээ тодорхой хэмжээгээр тусган хэрэгжүүлж, Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1 дэх заалтын дагуу бүрэн олгоно.	АОЭХ Үйлдвэр, ААНБ-ууд ҮЭ-ийн холбоод	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ АҮЭХ	Хамтын гэрээ, хэлэлцээрт тусгаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.	ОАҮЭХ-ны ҮНҮЭ-ийн хороод хамтын гэрээгээрээ ажилчдынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> • “ЭРДМИН” ХХК-ийн ажиллагсдын ҮЭ-ийн хороо нь 2019-2024 оны хугацаанд хамтын гэрээгээ 3 удаа шинэчлэн байгуулж, цалин хөлсийг 60 хувиар нэмэгдүүлсэн. • “ЭБЦТС” ТӨХК-ийн ажиллагсдын ҮЭ-ийн нэгдсэн хороо нь хамтын гэрээгээрээ 2020-2024 оны хугацаанд нийт ажилчдын цалингийн дунджийг 2.35 дахин нэмэгдүүлсэн гэх зэрэг... 	100%
5.3. Төр, төрийн үйлчилгээний болон аж ахуйн нэгж, байгууллагууд төсөв хүрэлцэхгүй гэдэг шалтгаанаар ажиллагсдын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг дутуу тооцож олгох, ээлжийн амралтын хугацааг уртасгаж цалингүй амраахыг хориглоно.	Аймгийн ЗДТГ-ын НБХ	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ	Зөрчил гарсан тохиолдолд тухайн зөрчлийг нь бүрэн арилгуулах арга хэмжээг авсан байна.	Орхон аймгийн ҮЭ-ийн холбоонд энэ асуудлаар өргөдөл, гомдол ирээгүй болно.	Үнэлэх боломжгүй
5.4. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа гэр бүлийн нэг гишүүний нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож орон нутгийн төсвөөс төлнө.	Аймгийн ЗДТГ-ын НБХ СТСХ	НДГ	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны салбар “Гэрэл” төвтэй хамтран хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх асран хамгаалагчдын эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардлыг 2014 оноос эхлэн 10 дэх жилдээ орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, ажилласан. 2023 онд 104 асран хамгаалагчдыг хамруулж	100%

				121.0 сая төгрөг зарцуулсан. Үүний үр дүнд асран хамгаалагчдыг нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох, эрүүл мэндийн үйлчилгээг бүрэн авах боломжийг бүрдсэн ба 2023 оны 07 дугаар сард батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тусгагдсанаар 2024 оны 01 дүгээр сараас эхлэн улсын хэмжээнд мөрдөгдөж эхлэн сайн жишиг болсон. 2024 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхийн шимтгэлд нийгмийн даатгалын сангаас 131 хүнд 78.4 сая төгрөг, 2025 оны 09 дүгээр байдлаар 119 хүнд 36.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас зарцуулсан.	
5.5. Хорт хавдартай болон хүнд өвчтэй иргэдийн эмчилгээ, өндөр үнэтэй оношилгооны зардалд зориулж 1 удаагийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгож, холбогдох эмнэлгүүдтэй хамтарч ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ЭМГ	Сумдын ЗДТГ ХХҮГ БОЭТ	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 2023 онд 162 иргэнд 69.8 сая төгрөг олгосон. 2024 онд 210 иргэнд 126.1 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна. 2024 онд шинээр батлагдсан 212 хавдрын тохиолдлын 99 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна. 2025 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 120.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс 2025 оны эхний хагас жилд аймгийн Засаг даргын 2025 оны А/123, А/463 дугаар захирамжаар 131 иргэнд 83.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар хорт хавдрын 164 тохиолдол шинээр бүртгэгдэж 10000 хүн амд 15.4 промилл, өмнөх	100%

				оны мөн үеэс 5.3 промиллоор өссөн. Шинээр бүртгэгдсэн хорт хавдраас 26.2 хувийг элэгний, 17.7 хувийг ходоодны, 7.9 хувийг умайн хүзүүний өмөн, 6.7 хувийг нойр булчирхайн, 41.5 хувийг бусад хавдар эзэлж байна.	
5.6. Иргэдийг эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан чанартай, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн /мах, гурил, ногоо, сүү/-ээр хангах, нөөцийг бүрдүүлэхэд орон нутгийн-ажил олгогч, үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллагыг бодлогоор дэмжинэ.	Аймгийн ЗДТГ ХБТХОХ Сумдын ЗДТГ	ХХААГ АҮЭХ АОЭХ ШӨХТГ	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Аймгийн хүн амын 2023 оны хаврын улирлын махны нийлүүлэлт, хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, эрүүл ахуй, ариун цэвэр, стандартын шаардлага хангасан үхэр, хонь, ямааны 200 тн махыг “Эрдмийт” ХХК, “Жаргалант мах импекс” ХХК-иуд, 2024 онд “Эрдмийт” ХХК 200 тн мах хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэж нийлүүлснээр хаврын улиралд махны хомсдол үүсээгүй, үнэ тогтвортой байж зах зээлийн үнээс үхрийн мах 1 кг нь 6200, хонины мах 1 кг нь 4867, ямааны мах 1 кг нь 3700 төгрөгөөр тус тус хямд нийлүүлэгдсэн. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс “Бүтлийн ундарга” ХХК-ийн улаан буудайн 3000 тонны багтаамжтай агуулахын барилга, байгууламж барих зориулалтаар 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авснаар улаан буудайн агуулах 3000 тн-оор нэмэгдэж, нийт агуулахын хэмжээ 10 ширхэг буюу 6640 тн-д хүрсэн. Мөн хүнсний бөөний худалдааны “Олон гурил” ХХК 400.0 сая, жимсний бөөний худалдааны “Заяа сор” ХХК 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авснаар хүнсний	100%

				гол нэрийн бүтээгдэхүүний агуулахын хэмжээ 130 тн-оор, жимсний тоноглогдсон хөргүүр 1-ээр, том оврын хүнсний тээврийн хэрэгсэл 2-оор нэмэгдсэн байна.	
5.7. Эрдэнэт хот дотор иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлж, хамрах чиглэлийн эцсийн зогсоолыг багийн айл, өрхийн алслагдсан хил хязгаарыг нарийвчлан гаргаж, тогтоосон хуваарийн дагуу амралтын өдрүүд, оройн цагаар тасалдалгүй тогтмол явуулж хэвшүүлнэ.	Аймгийн ЗДТГ ХБТХОХ АТТ	Сумдын ЗДТГ БГ ХТГ	Хэрэгжилт бүрэн хангагдаж, үйлчилгээ сайжирсан байна.	Орхон аймгийн "Авто тээврийг хөгжүүлэх" 4 зорилт 20 арга хэмжээ бүхий хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 16 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, ая тухтай байх ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлтийг хийснээр 79.1 хувь нь шинэчлэгдсэн. Аймгийн Засаг даргын А/597 дугаар захирамжаар Ч8: буюу "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол" чиглэл, А/620 дугаар захирамжаар Ч5: буюу "Хүлэг зах-Автовокзал-Говил" гэсэн чиглэлүүдийг тус тус баталсан. Шинээр батлагдсан Ч8, Ч5 чиглэлүүдэд 9 ширхэг автобусыг ХТГ-т хариуцуулан 2024 оны 07 дугаар сараас эхлэн нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж эхэлсэн. 2025 оны байдлаар 8 чиглэлд 38 дунд оврын автобус үйлчилгээнд явж байна. Нийтийн тээврийн 8 чиглэлд ажлын өдрүүдэд өглөө 07.00 цагаас 21.00 цаг хүртэл, амралтын өдрүүдэд 08.00 цагаас 20.00 цаг хүртэл том хүн 600, хүүхэд 300 төгрөгөөр иргэдэд үйлчилж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан болон үнэ төлбөргүй зорчих иргэдийн нөхөн олговорт 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. 2025	100%

				оны 09 дүгээр сарын байдлаар 38 автобуснаас 11 автобусны насжилт дуусаж шаардлага хангасан 65.5 хувь, шаардлага хангаагүй 34.5 хувь байна. 2026 оны орон нутгийн төсөвт нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлтийг хийхээр санал боловсруулан танилцуулга хийгдэж байна.	
5.8. Байр муу халах, ус тасрах зэргээр орон сууцанд оршин суугчдыг хохироосон тохиолдолд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэлийг үндэслэн халаалтын хөлс, усны үнийг тухайн үйлчилгээнд тохируулан багасгасан тохиолдолд холбогдох байгууллагууд хэрэглэгчид харилцах утсаар мэдээлэл өгөх ажлыг тогтмолжуулна.	ХЗА Эрдэнэт УДТС ОНӨХК	ХЭАХН ШӨХТГ СӨХ	Иргэд, хэрэглэгчдийг хохироосон зөрчил гарсан тохиолдолд тухайн зөрчлийг нь бүрэн арилгуулж, тэдгээртэй харилцах, мэдээлэл өгөх үйлчилгээг тогтмолжуулсан байна.	Орон сууцны байруудын халаалт доголдож байгаа талаар судалж үзэн Ус дулаан дамжуулах төвүүдийг өргөтгөх ажлыг зохион байгуулж байна. Мөн халаалтын талаар гомдол гаргасан иргэдийн байрны халаалтын төлбөрөөс хөнгөлөх мөн халаалтыг яаралтай сайжруулах ажлыг “ЭУДТС” ОНӨХК гүйцэтгэж байна. Мөн хэрэглэгчдэд халаалт усны төлбөрийн талаарх мэдээллийг мессежээр тогтмол илгээж байна. 2024-2025 оны халаалтын улиралд гарсан гомдлын дагуу газар дээр нь үзлэг хийж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гадна шугамыг шинэчлэх ажил хийгдэж байна.	70%
5.9. Эрүүл мэндийн даатгалаа төлсөн иргэд, ахмад настан, хүүхдүүд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхэд эм тариа гаднаас өөрсдөөс нь гаргуулсан тохиолдолд мөнгийг нь холбогдох хуулийн дагуу олгосон эсэх талаарх мэдээллийг тогтмолжуулж, хэрэгжилтэд нь нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.	Аймгийн ЗДТГ-ын НБХ	ЭМГ БОЭТ ХЭАХН ШӨХТГ	Хяналт сайжирч, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1.2 дахь заалт “Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах” гэсэн заалтын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг болон магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн ор бүхий 12 клиник Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Эрүүл мэндийн даатгалын тухай	100%

				хуулийн 13.1.8 дахь заалтын дагуу даатгуулагчийг хэвтүүлэн эмчлүүлэх үед өвчний түүхэнд бичигдсэн бичигдсэн эм тариа, материалын зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон иргэнд буцаан олгодог ба тайлант хугацаанд эм тариа гаднаас өөрсдөөс нь гаргуулсан тохиолдол бүртгэгдээгүй байна.	
5.10. Орон сууцанд оршин суугчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд нийгмийн түншлэлийн талууд хамтран хяналт тавина.	ХЗА ХЭАХН ШӨХТГ	Сумдын ЗДТГ ЭУДТС ОНӨХК	Хяналт сайжирч, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Оршин суугчдын аюулгүй, тайван орчныг бий болгох зорилгоор Баян-Өндөр сумын засаг даргын А/76 тоот захирамжаар байгуулагдан ажлын хэсэг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Нийт 5 багийн 109 байрны 629 зоорины хэсэг, грашууд хамрагдаж дараах зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> ◦ Подвалын хог хаягдлыг бүрэн цэвэрлэх ◦ Бүрэн гэрэлтүүлэгтэй болгох ◦ Цахилгаан болон үүрэн телефоны утсуудыг янзалж багцалж хэрэгтэй/холбогдох байгууллагуудад албан бичиг өгөх/ ◦ Шугамын хоолойн дулаалгын хөвөнг шуудайгаар ороож цэгцлэх ◦ Салхивчийг нээж онгойлгодог болгох /улирлаар/, хагарсан шилийг шинэчлэх, засварлах, солих ◦ Усны алдагдлыг бүрэн зогсоох дуудлага өгсөн бол эргэн хяналт хийх ◦ Алдагдсан ус бохирыг хатааж 	90%

				цэвэрлэх, ариутгалын бодис заавал цацах гэх мэт. Мөн 2025 онд 24 СӨХ-ны 128 байрны зоорины давхарт үзлэг хийж, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 2 удаа зохион байгуулсан байна.	
5.11. Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК, ЭДЦС ТӨХК, ЭБЦТС ТӨХК-ий хэрэглэгчдээс авч байгаа дулаан, цахилгааны суурь үнэ болон бусад үйлчилгээний тарифыг үндэслэлтэй тогтоож байгаа эсэхэд нийгмийн түншлэлийн талууд хяналт тавьж ажиллана.	ХЗА ХЭАХН ШӨХТГ	АҮЭХ АОЭХ	Нийгмийн түншлэлийн талуудын хамтарсан үзлэг, шалгалтыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Эрчим хүчний зохицуулах хорооноос батлагдсан үнэ тарифыг Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК, ЭДЦС ТӨХК, ЭБЦТС ТӨХК мөрдөн ажиллаж байна. Мөн тарифт үйлчилгээ авсан тохиолдолд төлбөрийн баримт дээр задаргааг гарган ажиллаж байна.	90%
5.12. Сульдаатай, тураалтай хүүхдийн зуны чийрэгжүүлэх сувиллын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрыг түшиглэн хүсэлт гаргасан ахмад настныг ахмадын сувилалд амраах үйлчилгээг үзүүлнэ.	Аймгийн ЗДТГ-ын НБХ	ЭМГ ХХҮГ ХБИН	Хэрэгжилт бүрэн хангагдаж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.	Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, Уян чагнуур ХХК-ийн Бүжинлхам эмнэлэг 2023 оны 06 дугаар сарын 15-наас эхлэн 7 ээлжээр ажиллан сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулан эмчлэн эрүүлжүүлсэн байна 2024-2025 онд суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр Бүжинлхам хувийн хэвшлийн хүүхдийн клиник сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 200 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны	100%

				сувилалд хамруулсан. Гэрээний хэрэгжилт 98 хувь байна. 2023 онд 312 ахмад амрааж 71826.5 сая төгрөг, 2024 онд 315 ахмад амрааж 87320.0 сая төгрөг, 2025 оны хагас жилээр 207 ахмад настан амрааж 62307.0 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн.	
5.13. Хүсэлтээ гаргасан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарих зориулалтаар газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу ногооны газар олгож тодорхой хугацаагаар эзэмшүүлж, үр дүнг тооцож ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ГХБХБГ	Сумдын ЗДТГ ХХААГ	Холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, хэрэгжилт хангагдсан байна.	2023 онд аймгийн хэмжээнд сумдын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 54 иргэнд 52.59 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөж 42 иргэнд 45.73 га газрыг иргэдийн гэр бүлийн хэрэгцээнд төмс хүнсний ногооны зориулалтаар эзэмшүүлсэн. 2024 онд Жаргалант сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар 40 нэгж талбарын 42.91 га газрыг сумын Засаг даргын захирамжаар, 2025 онд Жаргалант сумын Засаг даргын 2025 оны А/212 дугаар захирамжаар 18 иргэний төмс, хүнсний ногооны зориулалтаар 17.64 га газрыг давуу эрхээр тус тус эзэмшүүлсэн.	100%
5.14. Өөрийн орон сууц, хашаагүй хүсэлтээ гаргасан Орхон аймгийн харьяат иргэдэд амины орон сууц, хашаа барихад зориулж газар өмчлүүлэх ажлыг хуулийн дагуу тэгш эрхийн үндсэн дээр шударга зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ГХБХБГ	Сумдын ЗДТГ	Холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, хэрэгжилт хангагдсан байна.	2023 онд Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11/07 дугаар тогтоолоор Иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг батлуулж 308 иргэнд 25.12 га газрыг аймгийн Засаг даргын захирамжаар өмчлүүлсэн. 2024 онд Монгол улсын иргэнд шинээр газар эзэмшүүлэх гэрчилгээ олгох журамд өөрчлөлт орж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглахтай холбоотой хүсэлтийг Газрын нэгдмэл сангийн	100%

				<p>удирдлагын нэгдсэн цахим систем egazar.gov.mn болон төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем /e-mongolia/-ээр дамжуулан хүлээн авч Баян-Өндөр суманд 332 иргэнд 19.38 га газрыг шинээр эзэмшүүлсэн. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 137 дугаар тогтоолоор 2024 онд Орхон аймгийн хэмжээнд 5 байршилд 0.06 га газрыг үнээр нь өмчлүүлэхээр тусгагдаж, тухайн байршлуудыг аймгийн Засаг даргын захирамжаар өмчлүүлсэн. 2025 онд аймгийн хэмжээнд 321 иргэн 26.85 га газрыг өмчлөхөөр, 572 иргэнд 36.08 га газрыг эзэмшүүлэхээр Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор батлагдсан боловч Орхон аймаг Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа дууссантай холбогдуулан аймгийн хэмжээнд иргэдэд газар эзэмшүүлж, өмчлүүлэх боломжгүй байна.</p>	
5.15. Бололцоотой байрлалд байгаа гэр хорооллын багуудын төв, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхүүдийг төвийн дулаан, цэвэр, бохир усны шугамд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, ажиллах орчин, нөхцөлийг нь сайжруулах, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, усны зөв хэрэглээний талаарх бүх нийтийн ойлголт мэдлэг, амьдралын чанарыг	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ ХЗА	ГХБХБГ ЭУДТС ОНӨХК АҮЭХ АОЭХ	Иргэд, оршин суугчид эрүүл орчинд амьдах нөхцөл бүрдэж, зөв хэрэглээний талаарх ойлголт мэдлэг, амьдралын чанар нь дээшилсэн байна.	2021 оноос аймгийн хэмжээнд Бидний гудамж бидний гэр", "Хашаандаа хаус" хөтөлбөрийг хэрэгжүүлж гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажилд орон нутгийн төсвөөс нийт нийт 5.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг ажлын хүрээнд гэр хорооллын 7 багт нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдлээ. Төслийн	70%

<p>Нь дээшлүүлэхэд нийгмийн түншлэлийн талууд хамтарч ажиллана.</p>				<p>үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэж, 308 айл өрх бүрэн холбогдсон. Мөн инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэхээр улсын төсвийн нийт 19.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн Ус дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх шугам сүлжээний угсралтын ажлыг 2022 оноос эхлүүлснээр одоогийн байдлаар 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч ус дулаан хуваарилах төвийн дотор тоног төхөөрөмжийг угсарч дуусган, заслын болон гадна шугам угсралт, булалтын ажил хийгдсэн. УДДТ-ийн барилгын доторх тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байгаа ба нийт ажил 80%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. - Улсын төсвийн 1.37 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их залуу багт төв дулаан, цэвэр усны шугам шинээр тавих, ус дулаан дамжуулах төвийн барилга барих 1.7 км 3 хос гадна инженерийн шугам сүлжээ угсралтын ажлыг хийж дуусгалаа. - Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хотын нийтийн орон сууцнууд болон аж ахуйн нэгж, байгууллагыг төвлөрсөн дулаан 	
---	--	--	--	--	--

				<p>хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барих ажилд одоогийн байдлаар 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдон ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>-Ариутгах татуургын 3-р коллекторын төв шугамын ажлыг 2022 оноос эхлүүлснээр Ф200-Ф600мм-ийн гол шугам 6.4 км, салбар шугам 2.55км, Ф2000-1200мм-ийн 150ш худаг шугамын угсралт болон дулаалга, нягтруулалт зэрэг ажил хийгдсэнээр ажлын явц 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар хангагч байгууллагууд болох "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК болон "ЭДЦС" ТӨХК нь дулааны- 89, ус хангамж ариутгах, татуургын- 91 техникийн нөхцөлийг тус тус олгож иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд холбогдсон байна.</p> <p>2025 оны III улирлын байдлаар хангагч байгууллагууд болох "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК болон "ЭДЦС" ТӨХК нь дулааны- 19, ус хангамж ариутгах, татуургын- 18 техникийн нөхцөлийг тус тус олгож иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд холбогдсон байна.</p>	
5.16. Салбаруудын тарифын хэлэлцээрээр тогтоосон Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон цалин хөлсний нэмэгдлийг холбогдох аж ахуйн нэгж,	Аймгийн ЗДТГ	АҮЭХ АОЭХ	Холбогдох хууль тогтоомж, хэлэлцээрийн хэрэгжилтийг	Монгол улсын ЗГ-ын тогтоол шийдвэрүүдийг үндэслэн шат шатны удирдлагууд цалинг шинэчлэн тогтоох ажилд олон нийтийн хяналт	100%

байгууллагуудад заагдсан хугацаанаас нь эхлэн мөрдүүлж, түүний хэрэгжилтэд нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.			хангаж ажилласан байна.	тавин ажиллаж байна. Мөн ЗГ-ын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаартай тогтоолын 11 дүгээр хавсралтаар ТҮ-1 ангиллын цалингийн доод хэмжээ 900000 төгрөг болсонтой холбогдуулан ОАҮЭХ ажлын албаны үйлчилгээний ажилчдынхаа цалинг тус хэмжээнд хүргэн нэмэгдүүлсэн.	
5.17. Төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын ажлын их ачаалал, нормативыг судлан, хүн амын тоотой харьцуулж, бүтэц орон тоо, цалинг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох Төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний гурван талт хороонд тавьж, шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ СТСХ АҮЭХ АОЭХ	-	Нийгмийн түншлэлийн талуудын хамтарсан ажлын хэсэг байгуулж, нэгдсэн тооцоо, судалгааг холбогдох Төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний гурван талт хороонд Хүсэлт хүргүүлж, тодорхой шийдвэр гаргуулахад иргэд, хөдөлмөрчдийн бүх талын нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.	Төрийн албан хаагчдын цалин, хөлсийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр “Улсын төсөв-2025”-д саналаа тусгуулахаар Монголын Үйлдвэрчний Эвлэлийн холбоогоор уламжлан УИХ, ЗГ-т хүргүүлэх, УИХ-ын сонгуулийн 4 дүгээр тойрог (Орхон, Булган, Хөвсгөл аймаг)-оос УИХ-ын гишүүнээр сонгогдсон гишүүдэд хүсэлт хүргүүлэх зэрэг хэлбэрээр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.	100%
Зургаа. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх асуудал					
6.1. Үндэсний хэмжээний болон гадаад харилцааны түншлэлийн уулзалт-ярилцлага, сургалт, хурал зөвлөгөөнд болон орон нутгийн засаг захиргаанаас гадаадын орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогын хүрээнд туршлага солилцох, гэрээ хэлэлцээр байгуулах үйл ажиллагаанд аймгийн ҮЭ-ийн холбоо, Ажил олгогч эздийн холбооны төлөөлөгчдийг	Аймгийн ЗДТГ	АҮЭХ АОЭХ	Нийгмийн түншлэлийн талууд гадаадын орнуудын туршлага судалж, хамтын ажиллагаа өргөжсөн байна.	Үйл ажиллагаа хийгдээгүй болно.	0

<p>оролцуулж, талуудын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэхэд хамтарч ажиллана.</p>					
<p>6.2. Аймгийн бизнес эрхлэгчдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, аймгийн эдийн засгийг хөгжүүлэх, тэдний үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”, Зохистой хөдөлмөр эрхлэлтийн Бага чуулганыг нийгмийн түншлэлийн талууд хамтран хэлэлцээрийн хугацаанд зохион байгуулж, холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын СТСХ АОЭХ</p>	<p>-</p>	<p>“Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”, Зохистой хөдөлмөр эрхлэлтийн Бага чуулган зохион байгуулагдсан байна.</p>	<p>2023 онд Орхон аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Чехийн Эдийн засгийн Танхимтай хамтран хоёр орны бизнес эрхлэгчдийн уулзалт зохион байгуулж Чех улсаас 20 орчим аж ахуйн нэгж, Орхон аймгаас 40 гаруй аж ахуйн нэгжүүд оролцож хамтран ажиллах талаар санал солилцож, туршлага солилцсон. Бизнес уулзалтын хүрээнд хоёр талын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт, ганцаарчилсан уулзалтууд зохион байгуулагдсан ба Чехийн талаас барилгын зураг төсөл, үл хөдлөх хөрөнгийн зуучлал, өмгөөллийн фирм, эрүүл мэнд, эмийн үйлдвэрлэл, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрүүл мэндийн даатгал, хөдөлмөр зуучлал, тээвэр, логистик, зээлийн даатгал, зөвлөгөө үйлчилгээ, зэрэг салбарын аж ахуйн нэгжүүд оролцсон. Орхон танхим, Монгол Япон төвтэй хамтран "Хүний нөөцийн менежмент" сэдэвт сургалт зохион байгуулсан ба аж ахуйн нэгжүүд шинэ хүн ажилд авахаас илүү ажилчдаа тогтоон барих тал дээр анхаарч байна. ХАҮТанхимаас зохион байгуулдаг Өглөөний менежер клуб "Бизнес ба цаг хугацаа", “Өөрийгөө болон бусдыг шинжин таних” сэдвүүдээр сургалт зохион байгуулж 50 хүн оролцлоо. 2024 онд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан маркетингийн</p>	<p>100%</p>

				<p>зөвлөгөө өгөх өдөрлөгөө анх удаа Дархан хотод зохион байгуулагдаж энэхүү өдөрлөгийн хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд хийгдсэн маркетингийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны үр дүн танилцуулагдаж 150 бизнес эрхлэгчдэд 15 ментор үнэ төлбөргүй маркетингийн зөвлөгөө өгсөн. Бизнес эрхлэгчид зөвлөхүүдтэй биечлэн уулзаж, өөрсдийн тулгамдсан асуудалдаа шийдэл, шинэ санааг олж авахаас гадна бусад бизнес эрхлэгчид болон менторуудтай танилцан нэтворкинг хийх боломж олгосон. 2024 онд Орхон Танхим Голомт банктай хамтран "Дижитал аймаг-2024" үйл ажиллагааг зохион байгуулж Улаанбаатар хотоос технологийн чиглэлийн 29 аж ахуйн нэгж оролцож "Тогтвортой бизнесийг төлөвшүүлэх боломж" уулзалт болсон. Тус уулзалтаар байгаль орчинд ээлтэй, тогтвортой, ёс зүйтэй бизнестэй болох, бизнесээ олон улсад гаргах, экспорт хийх, хөрөнгө оруулалт татах, хувьцаа гаргах, хөнгөлөлттэй зээлд хамрагдах, ногоон санхүүжилт татах талаар мэдээлэл авсан. Мөн тус танхимаас тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ хийж, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг "Ризилиенс Консалтинг Сервиз" ХХК-тай хамтран Байгаль орчин, нийгэм засаглалын (БОНЗ) гэж юу болох, таны бизнест ямар давуу тал, боломжуудыг олгодог, ач холбогдлын талаар мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулж бизнесээ</p>	
--	--	--	--	--	--

				<p>олон улсын түвшинд, урт хугацаанд, эрсдэл багатайгаар, тогтвортой хөгжилд нийцүүлэн эрхлэх талаарх мэдээллийг бизнес эрхлэгчдэд олгосон.</p> <p>2025 оны 09 дүгээр сард Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Орхон аймагт худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдтэй худалдааны салбарын тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг сонсох, бизнесийн орчныг сайжруулах боломжуудыг хамтдаа эрэлхийлэх зорилгоор уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж 40 гаруй худалдаа эрхлэгч, иргэд оролцсон. Уулзалтын үеэр бодит асуудлуудыг хөндөн худалдааны орчны сайжруулалт, хяналт шалгалтын үйл ажиллагааны зохицуулалт, бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэлүүд, шийдлийн боломжууд, хамтын ажиллагааны хэлбэрүүдийг хэлэлцэж саналуудыг нэгтгэн баримтжуулж, холбогдох төрийн байгууллагад уламжлахаар болсон. Бичил, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх менторинг уулзалт, сургалтыг Хүнсний худалдаа эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд “Эдийн засгийн ногоон шилжилт” төсөлтэй хамтран явуулсан. Энэхүү төсөл нь Европын Холбооны Свитч Эйшиа хөтөлбөрөөс санхүүжилттэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд төслийн гол зорилго ногоон баталгаажуулалт, эко шошгожуулалт нэвтрүүлэх, тойрог эдийн засагт шилжихэд дэмжлэг үзүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний стратегид</p>	
--	--	--	--	---	--

				нийцэх юм. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос зохион байгуулж буй "Дундын хоршоо-Бизнес түншлэл" хоршоологчдын улсын зөвлөгөөн 2025 оны 09 дүгээр сарын 7-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Бага баян Энхийн төлөө цогцолбор төвд зохион байгуулагдсан. Тус зөвлөгөөнд 20 аймаг, нийслэлийн 180 гаруй хоршооны төлөөлөл оролцсоноос Орхон аймгаас 13 хүний бүрэлдэхүүнтэй оролцож мэдээлэл авсан.	
6.3. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор Сумын Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд Үйлдвэрчний эвлэлийн болон Ажил олгогч эздийн холбооны төлөөллийг оруулж ажиллуулна.	Сумдын ЗДТГ	АҮЭХ АОЭХ	Тогтоолын хэрэгжилтийг хангуулсан байна.	Баян-Өндөр сумын Засаг даргын зөвлөл нь 11 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Баян-Өндөр сумын Үйлдвэрчний хороон дарга С.Сэрээтэрдорж үйлдвэрчний эвлэлийн гишүүний хувиар оролцож байна. Жаргалант сумын Засаг даргын 2025 оны А/220 дугаар захирамжаар "Засаг даргын зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Шинэ зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын удирдлага, холбогдох мэргэжилтнүүдээс гадна иргэдийн оролцоог хангах зорилгоор сумын Ахмадын хороо, Залуучуудын холбоо болон иргэдийн төлөөлөл гэсэн нийт 3 иргэний төлөөллийг багтаасан байна. Ингэснээр зөвлөл нь сумын хөгжлийн бодлого, шийдвэр гаргалтад олон нийтийн төлөөллийг өргөнөөр хамруулах, иргэдийн дуу хоолойг төрийн үйл ажиллагаанд тусгах	90%

				боломжийг бүрдүүлж байгаа юм.	
6.4. Аймгийн Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхимын “Бизнес хөгжлийн төв”-ийн барилга барих газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд хамтран ажиллана. “Бизнес хөгжлийн төв”-ийн барилга баригдах хүртэлх хугацаанд Ажил олгогч эздийн холбооны албан ажлын байрны түрээсийн үнийг чөлөөлнө.	Аймгийн ЗДТГ ОНӨГ	АОЭХ	“Бизнес хөгжлийн төв”-ийн барилга барих газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.	Ажил олгогч эздийн холбооны үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж, 2010 оноос хойш орон нутгийн өмчийн Захиргааны 3 дугаар байрны 16.9 м2 талбай бүхий 215 тоот өрөөг ашиглалтын гэрээгээр эзэмшүүлэн ажиллаж байна.	100%
6.5. Хөдөлмөрийн тухай хууль болон ХАБЭА-н хууль тогтоомж, түүнтэй холбогдон гарсан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулах сургалт, мэдээллийн ажлын төсөл, хөтөлбөрүүдийн ажлыг нийгмийн түншлэлийн талуудаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.	АҮЭХ АОЭХ ХАБЭАСЗ	Аймаг, сумдын ЗДТГ	Хууль тогтоомжийг сурталчилах сургалт, төсөл, хөтөлбөрүүдийн ажлыг АҮЭХ, ААОЭХ-гоор гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.	Аймгийн Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран аж ахуйн нэгж, байгууллагуудад “Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх” мэдээллийн зөврийн самбар аялуулах, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн олон нийтийн хяналт” сэдэвт сургалт зохион байгуулах, бичил бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль”, холбогдох тогтоомжийг сурталчилж сургалт зохион байгуулах, Төр төсвийн байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дах заалтын хэрэгжилтийн судалгааг авч нэгтгэн мэдээллээр хангах, эрсдэлийн үнэлгээний арга зүй сургалтыг боловсролын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтанг хамруулан зохион байгуулж гарын	100%

				авлагаар хангах, ажилтны ажлын ачааллын өнөөгийн байдал, ажил, амралтын цагийн зохицуулалтын хэрэгжилт, үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт сэдвүүдээр онол, практикийн бага хурал зохион байгуулах, ажилтны ажлын ачааллын өнөөгийн байдал, ажил, амралтын цагийн зохицуулалтын хэрэгжилт, үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт сэдвүүдээр онол, практикийн бага хурал зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын ХАБЭА-н зөвлөлийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтууд, томоохон аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зэрэг 30 гаруй удаагийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээ, уулзалт зэргийг зохион байгуулж 300 гаруй байгууллагын 5000 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан.	
6.6. Хөдөлмөрийн харилцаан дахь нийгмийн түншлэлийн үйл ажиллагаанд хууль ёсны эрх, ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, бүх шатны Засаг дарга, түүний Тамгын газар дэмжиж ажиллана.	АҮЭХ АОЭХ	Аймаг, сумдын ЗДТГ	Нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ дэмжлэг үзүүлсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 талт хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд төлөөлөл ажиллуулж, ҮЭ-ийн идэвхтэн, сонгуультнууддаа болон нийт гишүүд, ажилтнуудад мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн ажил хэргийн хүрээнд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудаас гаргуулан авах зэргээр хамтран ажиллаж байна.	100%
6.7. Сумдад Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороодын гишүүдийг чадавхжуулах,	Аймгийн ЗДТГ- ын ХЭЗХ Сумдын ЗДТГ	АҮЭХ АОЭХ	Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн	70%

<p>дадлагажуулах ажлыг түншлэлийн талууд хамтарч зохион байгуулна.</p>	<p>ХМШЗСХ ХХҮГ</p>		<p>талт хороодын гишүүдийг чадавхжуулах, дадлагажуулах ажил зохион байгуулагдсан байна.</p>	<p>34 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог үндсэн 9 гишүүн, орлох 3 гишүүтэйгээр байгуулсан. 2023 онд хорооны гишүүдийг чадавхжуулах зорилгоор хороонд ирсэн өргөдлийг нэг кейс болгон тайлбарлаж, Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороо болон Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн чиглэл, мэдээлэл болгоныг тухай бүр танилцуулж мэдлэг, мэдээллээр хангаж байсан болно. Мөн гишүүдэд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулагаар хэвлэгдсэн номыг олгосон. 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны 9 гишүүдийг чадавхжуулах үүднээс Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хорооноос “Орхон аймгийн баян-өндөр сумын эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүдийг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулсан. 2025 онд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт хүлээгдэж байгаа болно.</p>	
<p>6.8. Сумдын Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороодын үйл ажиллагааны санхүүжилтийн асуудлыг сумын ИТХ, ЗДТГ хариуцаж, хяналт тавьж ажиллана.</p>	<p>Сумдын ЗДТГ ХМШЗСХ</p>	<p>АҮЭХ АОЭХ</p>	<p>Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороодын үйл ажиллагааны төсвийг сумын төсөвт тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж</p>	<p>2023 онд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, бичиг хэргийн зардал болон хорооны гишүүдэд урамшуулал олгосон. 2024 онд 5.400.000 төгрөг батлуулж, хорооны гишүүдийг урамшуулж, бичиг хэрэгт зарцуулсан. -2025 онд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 17 дугаартай</p>	<p>70%</p>

			ажилласан байна.	тогтоолоор 400.000 төгрөгийн санхүүжилттэй бөгөөд онлайнаар оролцох оролцогчдын эрхийг хангах үүднээс ZOOM холболтын эрхийг худалдаж авах, хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	
6.9. Сумдын Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талыг бүрдүүлэгч ажил олгогч, ажилтны эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль ёсны төлөөллийн байгууллагуудын түншлэлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор эдгээр байгууллагуудыг менежмент, санхүүгийн хувьд нэгдсэн зохион байгуулалттай үйл ажиллагааг нь байнгын хэвийн явуулахад сумдын төрийн байгууллагууд дэмжлэг үзүүлж ажиллана.	АҮЭХ АОЭХ	Сумдын ЗДТГ	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн талууд хамтын үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.1.6, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны 2022 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрмийн 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 34 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог үндсэн 9 гишүүн, орлох 3 гишүүтэйгээр байгуулсан. Уг хороо нь эхний бүтэн жилийн байдлаар 12 иргэний өргөдөл хүлээн авсан. Маргааныг төрлөөр нь авч үзвэл Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон 9, цалин болон ээлжийн амралтын хоног, цалин дутуу бодсон 2, хамтын гэрээтэй холбоотой 1 маргаан байв. Дээрх 12 маргаанаас 10 маргаан нь эвлэрэлээгүй, 1 маргаан эвлэрсэн, 1 маргаан өргөдлөө буцаан авсан байна. Мөн Хөдөлмөрийн сонирхлын маргааныг шийдвэрлүүлэхээр 2 зуучлагчийг томилж, 1 гомдол эвлэрч, 1 гомдлыг буцаасан болно.	90%
6.10. Төсөвт болон хувийн хэвшлийн аж	АҮЭХ	Аймгийн	Хөдөлмөрийн тухай	Орхон аймгийн ҮЭ-ийн холбоо	100%

<p>ахуйн нэгж, байгууллагуудад шинэ Хөдөлмөрийн тухай хууль, дүрэм, журамд нийцсэн хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журам, бусад хэм хэмжээг боловсруулж батлахад хэлэлцээрт оролцогч түншлэлийн талууд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ.</p>	<p>АОЭХ ХХҮГ</p>	<p>ЗДТГ-ын ХЭЗХ Сумдын ЗДТГ</p>	<p>хууль болон бусад хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, гэрээ, хэлэлцээрийн талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.</p>	<p>өөрийн нийт гишүүн байгууллагуудын 48 буюу 66.6 хувьд нь Зөвлөн туслах, хяналт шалгалт хийх үйл ажиллагааг тухайлсан удирдамжийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр ханган ажиллалаа. Тухайлбал: ОАҮЭХ Хөдөлмөрийн дотоод журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн ҮЭ-ийн хороо, Унага цэцэрлэг болон 1, 7, 15 дугаар цэцэрлэгийн ажиллагсдын ҮЭ-ийн хороо, Орхон аймаг дахь Политехник коллежийн ажиллагсдын ҮЭ-ийн хороо зэрэг нийт 7 ҮЭ-ийн хорооны хамтын гэрээний төсөлтэй танилцаж, арга зүйн зөвлөмж хүргүүлсэн. Мөн 2024 онд Хөдөлмөрийн хууль, тогтоомжийн холбогдох асуудлаар нийт 33 хүнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.</p>	
<p>6.11. Хэлэлцээрийн хугацаанд Шилдэг тэргүүний үйл ажиллагаатай 1-2 аймгийн нийгмийн түншлэлийн ажилтай танилцах, туршлага судлах ажлыг нийгмийн түншлэлийн талуудын оролцоог тэгш хангаж, зохион байгуулна.</p>	<p>АҮЭХ АОЭХ</p>	<p>Аймаг, сумдын ЗДТГ</p>	<p>Нийгмийн түншлэлийн талууд Шилдэг тэргүүний үйл ажиллагаатай 2 аймгийн нийгмийн түншлэлийн ажилтай танилцах, туршлага судласан байна.</p>	<p>Үйл ажиллагаа хийгдээгүй болно.</p>	<p>0</p>
<p>ДУНДАЖ ХУВЬ</p>					<p>92.7%</p>